



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН 2018

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
ӨМНӨХ ҮГ	8
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИ	10
ХУРААНГУЙ	11
1. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	13
1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ	13
1.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ.....	18
1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА	24
1.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО	28
2. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	35
2.1. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ	35
2.2. БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ	41
2.3. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ	42
2.4. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ.....	44
3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	47
3.1. САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	47
3.1.1. ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ	47
3.1.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ	49
3.2. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ	52
4. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	54
4.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	54
4.2. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	54
4.3. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА	56
4.4. ТӨСӨВ, САНХҮҮ.....	57

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг).....	2,511.8
Үнэт цаасны арилжааны дүн (тэрбум төгрөг)	245.5
Топ-20 индекс (нэгж)	21,466.8
Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (тэрбум төгрөг)	711.4
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны дүн (тэрбум төгрөг)	3,779.3
Хувьцаат компанийн тоо	305
Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдын тоо.....	54
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тоо.....	17
Хөрөнгө оруулалтын сан (хувийн)	12
Аудитын компани	56
Үнэлгээний компани	23
Хуулийн компани	26



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	331.9
Даатгалын хураамжийн орлого (тэрбум төгрөг).....	178.7
Хохирлын харьцаа	55.2%
Даатгалын нөхөн төлбөр (тэрбум төгрөг)	58.2
Нийт цэвэр ашиг (тэрбум төгрөг).....	18.4
Давхар даатгалын компанийн тоо.....	2
Урт хугацааны даатгалын компани	1
Даатгалын компанийн тоо	15
Даатгалын хохирол үнэлэгчдийн тоо	27
Даатгалын зуучлагчийн тоо.....	49
Даатгалын төлөөлөгчийн тоо.....	2,430
Аудитын компанийн тоо.....	43



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	1284.9
Нийт зээл (тэрбум төгрөг)	869.2
Нийт цэвэр ашиг (тэрбум төгрөг)	101.1
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.2%
Банк бус санхүүгийн байгууллагын тоо.....	539
Салбар, төлөөлөгчийн газрын тоо.....	230



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Нийт хөрөнгө (тэрбум төгрөг)	200.2
Нийт зээл (тэрбум төгрөг).....	133.8
Нийт цэвэр ашиг (тэрбум төгрөг)	5.3
Нийт хадгаламж (тэрбум төгрөг)	141.5
Хадгаламж, зээлийн хоршооны тоо	279
Салбарын тоо.....	27
Гишүүдийн тоо	62,556

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АТТ	“Арилжааны төлбөр тооцоо” ХХК
АЖДХ	Албан журмын даатгагчдын холбоо
АХБ	Азийн хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДБ	Дэлхийн банк
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЖАЙКА	Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
МББСБХ	Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо
МИК	“Монголын ипотекийн корпораци ОССК” ХХК
МХБ	“Монголын хөрөнгийн бирж” ХК
МҮЦБ	“Монголын үнэт цаасны бирж” ХК
МХЗХҮХ	Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
СХШБ	Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага
СҮА	Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг
ТХА	Техник хамтын ажиллагаа
ОУВС	Олон улсын валютын сан
ОУХОБ	Олон улсын хөрөнгө оруулалтын банк
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
ҮЦХОХ	Үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ХААБ	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль, зүй дотоод хэргийн яам
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ, ДНБ–д эзлэх ЗЗҮ–ний хувь, хөрвөх чадвар	13
Зураг 2. ТОП 20 Индекс	13
Зураг 3. MSE A болон MSE B Индекс	14
Зураг 4. Хувьцаат компанийн тоо	15
Зураг 5. Арилжааны гүйлгээний дүн бүтээгдэхүүний ангиллаар /тэрбум төгрөгөөр/	16
Зураг 6. Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ҮЦТХТ–д бүртгэгдсэн) гаргасан байдал	16
Зураг 7. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөгөөр/	17
Зураг 8. Шинээр нээгдсэн данс	17
Зураг 9. Арилжааны дүн, хөрөнгө оруулагчдын эзлэх хувиар	18
Зураг 10. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин	18
Зураг 11. Даатгалын нягтрал /төгрөгөөр/	19
Зураг 12. Даатгалын компаниудын нийт хөрөнгө, хөрөнгийн өсөлт	20
Зураг 13. Даатгалын компаниудын хураамжийн орлого, давхар даатгалын хураамж	20
Зураг 14. Даатгалын хураамжийн орлого /хэлбэрээр/	21
Зураг 15. Даатгалын нөхөн төлбөрийн зардал /хэлбэрээр/	22
Зураг 16. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 17. Цэвэр ашиг	23
Зураг 18. Цэвэр ахиуц ашиг, хосолсон харьцаа	23
Зураг 19. Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж	24
Зураг 20. Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	26
Зураг 21. Салбарын ангиллаар төлөгдсөн, олгосон зээл /хувиар/	26
Зураг 22. Зээлийн жигнэсэн дундаж хүү	27
Зураг 23. Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	28
Зураг 24. ХЗХ–дын тоо болон гишүүдийн тоо	28
Зураг 25. ХЗХ–дын тархалт /газарзүйн байршлаар/	30
Зураг 26. ХЗХ–дын нийт хөрөнгө, өсөлт	30
Зураг 27. ХЗХ–дын нийт хөрөнгөд эзлэх хувь /хөрөнгийн бүлгээр/	31
Зураг 28. ХЗХ–дын нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/	31
Зураг 29. ХЗХ–дын чанаргүй зээлийн үзүүлэлт /эзлэх хувиар/	32
Зураг 30. ХЗХ–дын нийт хадгаламж, өсөлт	32
Зураг 31. Нийт хадгаламжид эзлэх хувь /хадгаламжийн бүлгээр/	33
Зураг 32. ХЗХ–дын орлого ба зардал /тэрбум төгрөгөөр/	33
Зураг 33. ХЗХ–дын ашигт ажиллагааны өсөлт /хувиар/	34
Зураг 34. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /салбараар/	49
Зураг 35. Үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга	49
Зураг 36. Даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга	50
Зураг 37. ББСБ–ын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга	50
Зураг 38. ХЗХ–ны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга	51
Зураг 39. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа /хоногоор/	51
Зураг 40. Бүтэц	54

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлд оролцогчдын тоо болон үйл ажиллагааны чиглэл	14
Хүснэгт 2. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	15
Хүснэгт 3. Даатгалын зах зээл дэх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	19
Хүснэгт 4. Үндсэн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	24
Хүснэгт 5. Активын бүтэц /тэрбум төгрөгөөр/	25
Хүснэгт 6. Пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/	27
Хүснэгт 7. ХЗХ–дын тархалт /бүсээр/	29
Хүснэгт 8. ХЗХ–дын тоо, гишүүдийн үзүүлэлт /хүйс, байршлаар/	29
Хүснэгт 9. Зөвшөөрлийн тоо /Үнэт цаасны зах зээл/	41
Хүснэгт 10. Зөвшөөрөл, эрхийн тоо /Даатгалын зах зээл/	41
Хүснэгт 11. Зөвшөөрлийн тоо /ББСБ/	42
Хүснэгт 12. Зөвшөөрлийн тоо /ХЗХ/	42
Хүснэгт 13. Хяналт шалгалтад хамрагдсан зохицуулалттай этгээдийн тоо	43
Хүснэгт 14. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд үзлэг болон төрөлжсөн хяналт, шалгалтад хамрагдсан зохицуулалттай этгээдийн тоо	46
Хүснэгт 15. Захиргааны хэм хэмжээний акт	52
Хүснэгт 16. Архивын сан хөмрөгийн ашиглалт, баримт бичгийн эргэлтийн мэдээ	55



ӨМНӨХ ҮГ

хоршооны салбаруудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос 33 орчим хувиар өслөө.

Дэлхий дахинд санхүүгийн зах зээлийн зохицуулалт улам глобалчлагдаж, хурдацтай хөгжиж буй финтек (FinTech) буюу цахим технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний зохицуулалтад онцгойлон анхаарч байна. Хороо энэхүү олон улсын чиг хандлагаас хоцролгүй, Монгол Улсын санхүүгийн зах зээлд нэвтэрч буй финтект суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжихийн зэрэгцээ тэдгээрийг зохицуулахад чиглэсэн судалгаа, шинжилгээ хийж, олон улсын байгууллагаас санал, зөвлөмж болгож буй шийдлүүд, ойролцоо нөхцөл бүхий улс орнуудад нэвтэрч буй дэвшилтэт туршлагыг тандах зэргээр идэвхтэй ажиллалаа. Энэ бүхний үр дүнд санхүүгийн хүртээмж ихээхэн тэлж, зах зээлийн өрсөлдөөний нөлөөгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг цаг хугацааны явцад буурах нөхцөл бүрдэж буйг бидний дэлгэн барьж буй энэхүү Хорооны 2018 оны үйл ажиллагааны тайлангаас Та дэлгэрэнгүйгээр харж болно.

Өнгөрөгч онд Хорооны хийсэн нэг чухал ажил бол 2018–2021 оны стратеги, төлөвлөгөөгөө батлан, хэрэгжүүлж эхэлсэн явдал юм. Зах зээлийн өсөлт хөгжил, тогтвортой байдлыг бодлогоор чиглүүлж, түүнийхээ үндсэн дээр зохицуулалтыг оновчтой, үр дүнд чиглэсэн байдлаар явуулахыг үйл ажиллагааныхаа чиг шугам болгон

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 онд дэлхийн эдийн засгийн өсөлтийн хувиас даруй хоёр дахин өндөр байлаа. Экспорт болон хөрөнгө оруулалтын өсөлтөөс голлон бүрдсэн энэхүү өсөлт дотоодын эрэлтийг нэмэгдүүлж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж буй нь статистик судалгаанаас тодорхой харагдаж байна. Түүнчлэн Засгийн газрын өр буурч, гадаад валютын нөөц нэмэгдсэн зэрэг таатай үр дүн бүхий энэ онд Хороо санхүүгийн зах зээлд өсөлтийг дэмжих, тогтвортой байдлыг хадгалах, зохицуулалтыг сайжруулах зохистой бодлого баримтлан ажилласнаар үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ түүхэн дээд амжилтыг үзүүлсэн зэрэг бодитой ололтуудад хүрлээ. Хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн

боловсруулсан дунд хугацааны стратегиар санхүүгийн салбарыг нэгдсэн байдлаар харилцан уялдаатайгаар хөгжүүлэх, оролцогч тал бүрийг хамарсан бодлогоо тодорхойлж чадсаныг тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү бодлогын баримт бичгийг бид хамт олныхоо хүчин чармайлт, идэвх санаачилгаар боловсруулан баталсан бөгөөд дэлхий нийтийн санхүүгийн хөгжлийн чиг хандлагын дагуу алсын хараа, богино болон дунд хугацааны зорилго, зорилтыг тодорхойлж, үзүүлэлтүүд хэмжигдэхүйц байх үр дүнд хүргэх зарчмыг баримталсан юм.

Дунд хугацааны стратеги, зорилтоо хэрэгжүүлэх ажилд хугацаа алдалгүй орж, санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтыг эрчимжүүлэн, нийт 23 хууль, тогтоомж, 160 орчим дүрэм, журмын хэрэгжилтийг хангах хүрээнд 2500 орчим аж ахуйн нэгж, байгууллагад

зайны болон газар дээрх хяналт шалгалт явуулсны дээр санхүүгийн болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг Монгол Улсын хэмжээнд анх удаа хийлээ. Хяналт шалгалт болон үнэлгээний ажлаар илэрсэн зөрчил дутагдалд хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалах, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн цөөнгүй ажлыг зохицуулалтын салбар бүрт хийж ажиллалаа.

Цаашид Хороо бодлого стратегиа амжилттай хэрэгжүүлэх, зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, зах зээлийн тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэх үүднээс салбарын оролцогчдын мэргэжлийн болон эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА



С.ДАВААСҮРЭН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИ



АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт, тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож, эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж, олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.



ҮНЭТ ЗҮЙЛС

1. **Цогц мөн чанар:** Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;
2. **Хариуцлагатай байх:** Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;
3. **Мэргэжлийн байх:** Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;
4. **Бие даасан байх:** Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;
5. **Манлайлал, санаачлагатай байх:** Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;
6. **Багаар ажиллах:** Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь;

ХОРООНЫ ҮНЭТ ЗҮЙЛ ЮМ.

ОУВС–ийн шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2018 оны 4 дүгээр сард 3.9 хувьд хүрнэ хэмээн, оны эцэст уг дүнгээс бага зэрэг буурч өмнөх оны түвшинд буюу 3.7 хувьд хадгалагдана гэж үзлээ.

Экспортын өсөлтийн удаашралт, эрчим хүчний үнийн өсөлт, улс төрийн тодорхой бус байдал зэрэг нь өндөр хөгжсөн орнууд, тэр дундаа Евро бүсийн улсууд, Их Британийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Төсвийн бодлогын таатай нөхцөл нь хувийн секторын өсөлтийг дэмжиж АНУ–ын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалахад нөлөөлсөн бол эрчимтэй хөгжиж буй Азийн орнуудын эдийн засаг дотоод эрэлтийн нөлөөгөөр хурдацтай өсөлтөө хадгаллаа. Мөн газрын тосны үнийн өсөлт нь Саб Сахарын Африк, Ойрх Дорнодын улсуудын эдийн засагт эерэг нөлөө үзүүлсний зэрэгцээ Латин Америкийн улсуудын эдийн засгийн сэргэлт үргэлжилсэн хэвээр байна.

“Дэлхийн эдийн засгийн төлөв”–ийн мэдээлснээр дэлхийн эдийн засгийн өсөлт 2019, 2020 онуудад өмнөх оноос бага зэрэг удааширч тус тус 3.5, 3.6 хувьд хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна. АНУ, БНХАУ–д хэрэгжүүлж эхлэх татварын өсөлт, ХБНГУ–д тогтоосон автомашины хийн ялгаруулалтад ногдуулах стандарт, Итали улсын санхүүгийн зах зээлд тулгарч буй эрсдэл зэргээс шалтгаалан дотоодын эрэлт хумигдаж эдийн засгийн өсөлт удааширна гэж шинжээчид таамаглав.

2017 оноос сэргэж эхэлсэн Монгол Улсын эдийн засаг өмнөх оны өсөлтөө ахиулан 2018 оны жилийн эцэст 6.9 хувьд хүрлээ. Эдийн засгийн өсөлтийг экспорт болон хөрөнгө оруулалтын өсөлт голлон бүрдүүлсэн ба хөрөнгө оруулалтын өсөлт нь дотоодын эрэлтийг нэмэгдүүлж байна. 2018 оны эдийн засгийн өсөлтийг салбарын ангиллаар харвал 18.1 хувийг үйлчилгээний салбар, 16.2 хувийг уул, уурхайн салбар, 28.4 хувийг бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт тус тус бүрдүүллээ.

Түүнчлэн олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний “Стандарт энд Пүүрс” агентлаг 2018 оны 11 дүгээр сард Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн

үнэлгээг “В–” байсныг “В” болгон дээшлүүлж, өмнөх төлөвийг тогтвортой хэвээр хадгаллаа. Зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэхдээ тус агентлаг манай улсын эдийн засагт хүчтэй сэргэлт ажиглагдаж, засгийн газрын өр буурсан, гадаад валютын нөөц нэмэгдсэн зэрэг үр дүнг харгалзан үзжээ.

ОУВС–ийн шинжээчдийн төсөөллөөр Монгол Улсын эдийн засаг 2019 онд 6.3 хувь, 2020 онд 4.9 хувийн өсөлтийг үзүүлэх бол Азийн хөгжлийн банкны шинээжчдийн төсөөллөөр эдийн засаг 2019 онд 6.1 хувиар өснө гэж таамаглаж байна.

Макро эдийн засгийн таатай нөхцөл байдал болон зохицуулагч байгууллагаас хэрэгжүүлж буй зохистой бодлого, шийдвэрийн үр дүнд санхүүгийн зах зээл хурдтай өсөлтөө хадгалж, хөрөнгийн зах зээлд оролцогчдын идэвх сэргэж, итгэл нэмэгдэж байна. Тухайлбал, өнгөрөгч 2018 онд хөрөнгийн зах зээлд түүхэн дэх хамгийн өндөр дүнгээр арилжаа хийгдэж, зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөгт хүрсэн нь нэрлэсэн ДНБ–ий 7.8 хувьтай тэнцэж байна. Харин даатгалын компани, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 32.9 хувиар өсөж 1.8 их наяд төгрөгт хүрлээ. Ийнхүү банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хэмжээ ДНБ–д харьцуулсан дүнгээр 13.5 хувьд хүрлээ.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хувьцааны арилжааны хэмжээг өмнөх онтой харьцуулахад өндөр өсөлттэй байгаа нь зах зээлд оролцогчдын хөрөнгийн зах зээлд итгэх итгэл нэмэгдэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх сэргэсэнтэй холбоотой юм. Мөн тайлант онд 6 компани анхдагч зах зээлд хувьцаагаа амжилттай арилжаалсан нь хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх хамгийн олон компанид анхдагч зах зээлд хөрөнгө татах зөвшөөрөл олгосон үйл явдал юм. Эдгээр 6 компанийн 5 нь зах зээлээс 26.7 тэрбум төгрөгийг босгож чадсан байна. Түүнчлэн Монголын анхдагч хувийн бирж болох “Монголын үнэт цаасны бирж” ХК–

ийн хамгийн анхны бондын арилжаа явагдлаа.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын гүнзгийрэлт, нягтрал зэрэг нь олон улсын дундаж түвшинтэй харьцуулвал доогуур түвшинд байна. Энэ нь иргэдийн санхүүгийн суурь боловсролыг нэмэгдүүлэх, даатгалын хүртээмжийг сайжруулах, даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох нэн шаардлагатайг илэрхийлж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттай нэмэгдүүлэх шийдвэртэй холбогдуулан банк бус санхүүгийн байгууллагуудын нийт актив 2018 оны эцэст 1.3 их наяд төгрөгт хүрлээ. Тус шийдвэрийн үр дүнд салбарын мэргэжлийн оролцогчдын хөрөнгийн чадавх сайжирч, зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэн, зээлийн бүтээгдэхүүний үнэ болох хүүгийн түвшин буурч эхлээд байгаа ба өмнөх онд 3.4 хувь байсан зээлийн жигнэсэн дундаж хүү тайлант онд 3.2 хувь болж буурлаа.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарын хувьд мөн өндөр өсөлттэй жил болж, нийт хөрөнгийн хэмжээ 30.7 хувиар өсөв. Тус өсөлтөд нийт хадгаламжийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн ба салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжирчээ.

Санхүүгийн үйлчилгээг боломжийн хямд өртгөөр хүргэх таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний нэгжийн өртгийг бууруулах, шинэ технологийн хэрэглээг бий болгох бодлогыг боловсруулах, тогтвортой, бүрэн, хүртээмжтэй санхүүгийн салбарыг бий болгох зорилгыг хангах зохицуулалтын бүтцийг бий болгох, бага, дунд орлоготой иргэдэд санхүүгийн салбарын үйлчилгээг хүргэх зорилгоор үйлчлүүлэгчийг хамгаалах, эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, мэдээлэл цуглуулах, шинжлэх замаар санхүүгийн хүртээмжийн хандлагын өөрчлөлтийг бий болгон бодлогыг боловсруулах нь өнөөгийн даяаршлын чухал зорилт болж байна.

Банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Хороо нь өнөөгийн байдлаар 23 хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. Мөн Хороо нь холбогдох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд нийт 2,347 зохицуулалттай хуулийн этгээдийн санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор зохицуулалтын салбар, чиглэл тус бүрээр тодорхой ажлуудыг хийв.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


1.1. Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн үнэлгээ: 2018 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,511.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.5 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тайлант үед нийт 210.3 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 8.4 хувь болов. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 пунктээр өссөн үзүүлэлт.

Зах зээлийн үнэлгээг 2018 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ий хэмжээтэй харьцуулахад 7.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.9 пунктээр буурсан үзүүлэлт юм. Тус үзүүлэлт буурахад ДНБ-ий өсөлт голчлон нөлөө үзүүлжээ.


Зураг 1. Зах зээлийн үнэлгээ, ДНБ-д эзлэх ЗЗҮ-ний хувь, хөрвөх чадвар



Хувьцааны индекс: Тайлант үед ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 729.8 нэгжээр буюу 3.5 хувиар өсөж 21,466.8 нэгж болсон бөгөөд индексийн

дээд үзүүлэлт 21,737.7 нэгж, доод үзүүлэлт 18,861.4 нэгж, дундаж үзүүлэлт 20,157.0 нэгж байна.

Зураг 2. ТОП 20 Индекс




MSE A болон MSE B: “Монголын хөрөнгийн бирж” ХК нь “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-ыг шинэчлэн баталж 2018 оны 2 дугаар сараас эхлэн үнэт цаасны бүртгэлийн I болон II дугаар ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцож байна.

Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 1,1091.79 нэгж, доод үзүүлэлт нь 8,872.87 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,661.84 нэгж байна.

MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 10,202.94 нэгж, доод үзүүлэлт нь 8,284.32 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,388.79 нэгж байна.

Зураг 3. MSE A болон MSE B Индекс




Үнэт цаасны зах зээлд оролцогчдын тоо болон үйл ажиллагааны чиглэл: Монголын үнэт цаасны зах зээлд дараах төрлийн этгээдүүд зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлд оролцогчдын тоо болон үйл ажиллагааны чиглэл

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	2017	2018	Өөрчлөлт	
		Оролцогчдын тоо		Тоо	Хувь
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2	2	-	-
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1	1	-	-
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1	1	-	-
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	17	17	-	-
5	Хөрөнгө оруулалтын сан (хувийн)	9	12	3	33.3
6	Кастодиан банк	3	3	-	-
7	Андеррайтерийн зөвшөөрөлтэй банк	1	2	1	100
Мэргэжлийн оролцогчид:		52	54	2	3.8
8	Брокер	50	53	3	6
9	Дилер	47	41	(6)	(12.8)
10	Андеррайтер	22	25	3	13.6
11	Хөрөнгө оруулалтын зөвлөх	14	14	-	-
НИЙТ		85	90	5	5.9
12	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1	1	-	-
13	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	16	12	(4)	(25)
14	Аудитын компани	49	56	7	14.3
15	Үнэлгээний компани	21	23	2	9.5
16	Хуулийн компани	21	26	5	23.8

Хороонд бүртгэлтэй хувьцаат компани (ХК)-ийн тоо: Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 305 компани бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд Хорооноос нийт 6 компанид

олон нийтэд үнэт цаасаа нээлттэйгээр арилжих зөвшөөрөл олгосон бөгөөд 5 нь энэ онд анхдагч зах зээлд хувьцаагаа санал болголоо.



Хороо, Арилжаа эрхлэх байгууллага болон Хадгаламжийн байгууллагад бүртгэлтэй үнэт цаасыг өмчийн бүтцээр ангилан харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт 2. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	Хороо	Арилжаа эрхлэх байгууллага	"ҮЦТХТ" ХХК
Төрийн өмчит	31	18	21
Төрийн өмчийн оролцоотой	19	11	23
Хувийн өмчит	255	188	284
Нийт	305	217	328

Арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд бүртгэлтэй ХК-ийн тоо зөрүүтэй байгаа явдал нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар арилжаа эрхлэх байгууллага бүртгэлийн журмаа боловсруулж, Хороогоор батламжлуулж, журмын хүрээнд бүртгэлийн шалгуур шаардлагыг тогтоох, бүртгэлийн шаардлага хангаагүй бүртгэлтэй компанийг өөрийн бүртгэлээс хасдагтай холбоотой.


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан ХК-ийг өөрийн бүртгэлээс шууд хасах боломжгүй бөгөөд хөрөнгийн үнэлгээнд тулгуурлан нэгж хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг гаргуулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөхгүй, гомдол гаргахгүй нөхцөл бүрдсэн нөхцөлд үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах шийдвэр гаргадаг нь хоёр байгууллагын бүртгэлийн зөрүүтэй байдлыг үүсгэдэг.

Үнэт цаасны арилжаа: МХБ: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6.3 мянган ширхэг бондыг 631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 244.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

МҮЦБ: Тайлант улиралд МҮЦБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар 100 мянган ширхэг компанийн бондыг 1 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6,600 ширхэг компанийн бондыг 66 сая төгрөгөөр, 6.4 сая ширхэг хувьцааг 292.1 сая төгрөгөөр тус тус арилжаалав.


МХБ болон МҮЦБ-ээр өссөн дүнгээр нийтдээ 245.5 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан бөгөөд өмнөх оны мөн үеийн дүнгээс 615.3 тэрбум төгрөгөөр буурчээ. 2017 онд нийт арилжааны гүйлгээний 89.8 хувийг ЗГҮЦ-ны арилжаа бүрдүүлж байв.

Зураг 5. Арилжааны гүйлгээний дүн бүтээгдэхүүний ангиллаар /тэрбум төгрөгөөр/




Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: 2018 онд “МИК актив ТЗК 15–18” ХХК–д тусгай зөвшөөрөл олгож, үнэт цаасыг бүртгэв.

Зураг 6. Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ҮЦТХТ–д бүртгэгдсэн) гаргасан байдал



Хөдөө аж ахуйн биржийн арилжаа: ХАА–н биржээр дамжин 2018 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 711.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 164.2 тэрбум төгрөг буюу 30.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 7. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны үнийн дүн /тэрбум төгрөгөөр/



Үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчид, дансны бүтэц: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 1,304,371 данс, 160,805 холболтын данс нээгдсэн. Нийт нээгдсэн данснаас 1,299,268 дотоодын иргэн, 2,198 гадаадын иргэн, 2,712 дотоодын аж ахуйн нэгж, 193 гадаад аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 398,255 данс шинээр нээгдсэнээс 398,081 нь дотоодын иргэн, 80 нь гадаадын иргэн, 88 нь дотоодын аж ахуйн нэгж, 6 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна. Мөн 17,561 холболтын данс шинээр нээгдсэн.


Зураг 8. Шинээр нээгдсэн данс



Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь: 2018 оны жилийн эцсийн байдлаар хувьцааны, ЗГҮЦ-ны болон компанийн бондын хоёрдогч зах зээлийн нийт арилжааны дүнд хөрөнгө оруулагчдын эзлэх хувиар

ангилан авч үзвэл дотоодын иргэн 20.0 хувь, дотоодын ААН 40.8 хувь, гадаадын иргэн 2.8 хувь, гадаадын ААН 36.4 хувийг тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 9. Арилжааны дүн, хөрөнгө оруулагчдын эзлэх хувиар




1.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ олон улстай

харьцуулахад доогуур байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.56 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.03 пунктээр өссөн үзүүлэлт юм.


Зураг 10. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин



Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. 2018 оны жилийн эцсийн байдлаар нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ

56,233.6 төгрөг болж өмнөх оноос 19.2 хувиар өслөө. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм. Иймд 2018 оны жилийн эцсийн байдлаар үзүүлээ.

Зураг 11. Даатгалын нягтрал /төгрөгөөр/



Үндсэн үзүүлэлтүүд: Даатгалын зах зээлд 2018 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 15 ердийн даатгалын компани, 1 урт хугацааны даатгалын компани, 2 давхар даатгалын компани, 49 даатгалын зуучлагч компани, 27 даатгалын


хохирол үнэлэгч компани болон даатгалын компанийн 246 салбар, 12 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 275 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 43 салбар, 18 төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 3. Даатгалын зах зээл дэх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Компани, мэргэжлийн оролцогчид	2017	2018	Өөрчлөлт	
	тоо	тоо	Тоо	Хувь
Ердийн даатгал	15	15	-	-
Урт хугацааны даатгал	1	1	-	-
Давхар даатгал	1	2	1	100
Даатгалын төлөөлөгч	2893	2430	(463)	(16)
Даатгалын зуучлагч	42	49	7	16.7
Хохирол үнэлэгч	29	27	(2)	(6.9)
Актуарч	21	28	7	33.3
Аудитор	130	141	11	8.5
Аудитын компани	42	43	1	2.4


Даатгагчийн хөрөнгө: Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 35.6 хувь, өмнөх улирлаас 1.3 хувиар өсөж 331.9 тэрбум төгрөгт хүрлээ. Давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад илүү өндөр буюу 61.8 хувиар өсөж 70.2 тэрбум төгрөг болж, нийт хөрөнгийн

21.2 хувийг эзлэв. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 30.6 хувиар өсөж 252.9 тэрбум төгрөг болсон нь салбарын нийт хөрөнгийн 76.2 хувийг, харин урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 14.3 хувиар өсөж 8.9 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 2.7 хувийг эзэллээ.

Зураг 12. Даатгалын компаниудын нийт хөрөнгө, хөрөнгийн өсөлт

Даатгалын компаниуд энэ оны жилийн эцсийн байдлаар нийт 178.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс ердийн даатгалын компаниуд 175.5 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 1.4 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 1.7 тэрбум

төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлэв. 2017 онд хураамжийн орлого өмнөх онтой харьцуулахад 26 хувийн өсөлттэй гарч байсан бол 2018 онд 23.8 хувийн өсөлтийг үзүүлэв.

Зураг 13. Даатгалын компаниудын хураамжийн орлого, давхар даатгалын хураамж

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант онд 58.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 32.6 хувийг эзлэв. Өнгөрсөн онтой харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.1 хувийг бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд нийт 55.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өнгөрсөн оноос 18.7 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой

харьцуулахад 31 хувь байна. Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд 54.5 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 825.3 сая төгрөг, урт хугацааны даатгалын компани 22.4 сая төгрөгийг зарцуулжээ.

Даатгалын зах зээл дээр ердийн, урт хугацааны болон давхар даатгалын нийт 23 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас бусад бүх хэлбэрийн даатгал нь сайн дурын үндсэн дээр хийгдэж байгаа билээ.

Тайлант хугацаанд даатгалын зах зээлийн хэмжээнд нийт 178.7 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас ердийн даатгал 175.5 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 98.2 хувь, урт хугацааны даатгал 1.4 тэрбум төгрөг буюу 0.8 хувь, давхар даатгал 1.7 тэрбум төгрөг буюу 1 хувийг бүрдүүлэв.

Даатгалын компанийн хураамжийн орлогын 70 гаруй хувийг хөрөнгийн даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгал болон гэнэтийн осол, эмчилгээний даатгал бүрдүүлж байна.

Зураг 14. Даатгалын хураамжийн орлого /хэлбэрээр/



Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 39.8 тэрбум төгрөг буюу 22.3 хувийг, даатгалын төлөөлөгчид 36.9 тэрбум төгрөг буюу 20.6 хувийг бүрдүүлсэн байна. Даатгалын зуучлагчаар дамжин орсон хураамжийн орлогын 28.9 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал эзэлж байгаа бол төлөөлөгчөөр дамжин орсон хураамжийн орлогын 31 хувийг эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөр: Нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 57.1 тэрбум төгрөг буюу 98.1 хувь, урт хугацааны даатгал 559.3 сая төгрөг буюу 1 хувийг,


давхар даатгал 521.9 сая төгрөг буюу 0.9 хувийг эзэлж байна. Нийт нөхөн төлбөрийн зардлын бүтцийн хувьд эхний дөрвөн даатгалын хэлбэр нийт нөхөн төлбөрийн зардлын 80 орчим хувийг бүрдүүлээ. Нийт хураамжийн орлогын бүтцэд хөрөнгийн даатгал, нийт нөхөн төлбөрийн зардалд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хамгийн их хувийг эзэлж байна. Түүнчлэн тайлант жилд барилга угсралтын даатгалын нөхөн төлбөрийн зардал нэмэгдсэн ба 2017 онд нийт нөхөн төлбөрийн зардлын 4 хувь байсан бол 2018 онд 14.5 хувь болж өсжээ.

Зураг 15. Даатгалын нөхөн төлбөрийн зардал /хэлбэрээр/



Албан журмын даатгал: 2012 оноос жолоочийн албан журмын хариуцлагын даатгал хэрэгжиж эхэлсэн юм.

Зураг 16. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/



Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого 2017 онд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.5 хувийн өсөлтийг үзүүлж байсан бол тайлант онд 8.3 хувийн өсөлттэй байлаа. Улмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамжийн орлого тайлант онд 33 тэрбум төгрөг болж, нийт даатгалын хураамжийн орлогын 18.5 хувийг эзэлж байна. Харин нөхөн төлбөрийн хувьд өнгөрсөн онд 4.7 хувийн өсөлттэй байсан бол энэ онд 10 хувиар өсөж, 17.1 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын нийт нөхөн төлбөрийн зардлын 29.3 хувийг бүрдүүлжээ.


Тус даатгалын бүтээгдэхүүний нөхөн төлбөр болон хураамжийн орлогын харьцаа 2016 оноос эхлэн харьцангуй тогтворжих төлөвтэй байгаа ба сүүлийн 5 жилийн дунжийг авч үзвэл 56 хувь байгаа юм. Харин тайлант улиралд дунджаас ялимгүй доогуур 51.7 хувийн үзүүлэлттэй байлаа.

Тайлант онд даатгалын компаниудын цэвэр ашиг өнгөрсөн онтой харьцуулахад 5.2 тэрбум төгрөгөөр буюу 39.7 хувиар өсөж 18.4 тэрбум төгрөг болсон байна. Татварын дараах цэвэр ашгийн өсөлтийг бүлэглэн авч үзвэл хасах өсөлттэй буюу цэвэр ашгийн хэмжээ буурсан 8 даатгалын

компани, 50 хувь хүртэлх өсөлттэй 5 даатгалын компани, 50 хувиас 100 хувийн өсөлттэй 1 даатгалын компани, 100 хувиас дээш өсөлттэй 3 даатгалын компани байна.

Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашгийн хэмжээ дунджаар 1.9 дахин өсжээ.

Зураг 17. Цэвэр ашиг /тэрбум төгрөг/




Хохирол нөхөлтийн харьцаа тайлант онд өнгөрсөн онтой харьцуулахад ялимгүй өссөн үзүүлэлттэй байв. Энэ нь нийт нөхөн төлбөрийн зардал 28.7 хувиар, орлогод тооцсон хураамж 27.5 хувиар өссөнтэй, өөрөөр хэлбэл орлогод тооцсон хураамжийн өсөлт нөхөн төлбөрийн зардлын өсөлтөөс бага байсантай холбоотой юм. Салбарын хэмжээнд зардлын хосолсон харьцааг авч үзвэл нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардал нийт

орлогод тооцсон хураамжийн орлогын 101.6 хувьтай тэнцэв. Зардлын хосолсон харьцаа 2017 онд өссөн үзүүлэлттэй байсан бол тайлант онд буурсан байна.

Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант онд өссөн үзүүлэлттэй байна. 2016 онд цэвэр ахиуц ашиг 10 хувь, 2017 онд буурч 9.1 хувь болж байсан бол тайлант онд эргэн өсөж 10.3 хувьд хүрлээ.


Зураг 18. Цэвэр ахиуц ашиг, хосолсон харьцаа



Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2010 онд хамгийн өндөр буюу 22.7 хувь байсан бол 2014 онд уг үзүүлэлт буурч 3 хувьд хүрсэн билээ. 2014 оноос хойш өөрийн хөрөнгийн өгөөжийн харьцаа өсөх хандлагатай байгаа бөгөөд тайлант хугацаанд өмнөх оноос 1.4 пунктээр өссөнөөр 13 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн графикайн чиглэлд ижил төлөв ажиглагдаж байна. 2014 онд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 1.4 хувьд хүрсэн боловч дараах жилүүдэд сэргэж эхэлсэн. Тайлант хугацаанд нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өсөж 5.6 хувьтай байна.

Зураг 19. Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж



1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Салбарын өнөөгийн байдал: Хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудын тоо 2018 оны жилийн эцэст 539 болж өмнөх оноос 0.9 хувиар өссөн байна.

ББСБ-ууд нь бичил, жижиг, дунд, өрхийн бизнес эрхлэгчдэд зээл, валют арилжаа, итгэлцэл, факторинг, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, төлбөрийн баталгаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах зэрэг санхүүгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөл, зохицуулалтын хүрээнд хүргэж үйлчилдэг.

Давхардсан тоогоор зээлийн үйл ажиллагааг 492, гадаад валютын арилжааг 157, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг 31, итгэлцлийн үйлчилгээг 30, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 25, факторингийн үйлчилгээг 22, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээг 18, цахим төлбөр тооцоо, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээг 9, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээг 3 ББСБ тус тус эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

Хүснэгт 4. Үндсэн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2017	2018	Өөрчлөлт
		Дүн, тоо	Дүн, тоо	Хувь
1	Нийт ББСБ-ын тоо	534	539	0.9
Үүнээс: Хөдөө орон нутагт		70	73	4.3
2	Харилцагчдын тоо	1,471,099	1,601,749	8.9
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,039	4,875	369.2
4	Ажиллагсдын тоо	2,473	2,784	12.6
5	Салбар нэгжийн тоо	164	230	40.2
Үүнээс: Улаанбаатар хотод		114	161	41.2

Хөдөө орон нутагт		50	69	38
6	Төлөөлөгчийн газар	4	5	25
7	Нийт хөрөнгө	969.2	1,284.9	32.6
Банкны салбартай харьцуулахад /хувиар/		3.4%	3.9%	0.5
8	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	638.0	869.2	36.2
Банкны салбартай харьцуулахад /хувиар/		4.8%	5.4%	0.6
9	Нийт өөрийн хөрөнгө	758.2	977.4	28.9
Банкны салбартай харьцуулахад /хувиар/		24.1%	30.0%	5.9
10	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	595.4	740.8	24.4
Банкны салбартай харьцуулахад /хувиар/		81.7%	83.8%	2.1

ББСБ–уудын нийт актив 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.9 хувь, зээлийн өрийн үлдэгдэл 869.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 5.4 хувь, өөрийн хөрөнгө 977.4 төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 30.0 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 740.8 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 83.8 хувьтай тус тус тэнцэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн тоо тайлант онд өмнөх оноос огцом буюу 369.2 хувиар өссөн нь тайлант онд ББСБ–ын салбараас анх удаа анхдагч зах зээлд хөрөнгө босгосон буюу 1 банк бус санхүүгийн байгууллага хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компани

болсонтой холбоотой. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ–уудын 28.0 хувь буюу 44 нь уг үйл ажиллагааг дагнан эрхэлж байна.

Нийт хөрөнгө: Салбарын нийт хөрөнгө 1,284.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 32.6 хувиар буюу 315.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлтөд өөрийн хөрөнгө 219.3 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 145.4 тэрбум төгрөгөөр буюу 24.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн. Нийт активын 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаагийн 67.6 хувийг зээл, 24.5 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 5. Активын бүтэц /тэрбум төгрөгөөр/


Үндсэн үзүүлэлтүүд	2017		2018		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	932.7	96.2%	1234.7	96.1%	302.0	32.4
Мөнгөн хөрөнгө	264.1	27.3%	315.1	24.5%	51.0	19.3
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	2.7	0.3%	1.8	0.1%	(0.9)	(33.3)
Нийт зээл	638.0	65.8%	869.2	67.6%	231.2	36.2
(Зээлийн эрсдэлийн сан)	-56.0	-5.8%	-64.5	5.02%	(8.5)	15.2
Нийт факторингийн тооцооны авлага	0.1	0.0%	7.3	0.57%	7.2	7200
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	-	0.0%	0.0	0.0%	-	-
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	8.1	0.8%	10.2	0.8%	2.1	25.9
Бусад хөрөнгө	75.7	7.8%	95.5	7.4%	19.8	26.2
Эргэлтийн бус хөрөнгө	36.5	3.8%	50.2	3.9%	13.7	37.5
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	45.5	4.7%	61.5	4.8%	16.0	35.2
(Хуримтлагдсан элэгдэл)	9.0	0.9%	11.3	0.9%	2.3	25.6
НИЙТ ХӨРӨНГӨ	969.2	100%	1284.9	100%	315.7	32.6

Нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оноос 36.2 хувиар буюу 231.2 тэрбум төгрөгөөр өсөж 869.2 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт зээлд эзлэх гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан бол, төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ 233.3 тэрбум төгрөгөөр буюу 38.5 хувийн өсөлттэй байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор

нийт 234,080 зээлдэгчдэд хүрч үйлчилсэн.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 86.6 хувийг хэвийн, 3.8 хувийг хугацаа хэтэрсэн, 9.5 хувийг чанаргүй зээл тус зээлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 3.2 пунктээр буурчээ.

Зураг 20. Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/




Нийт олгосон болон төлөгдсөн зээлийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарт ногдох хувь дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 21. Салбарын ангиллаар төлөгдсөн, олгосон зээл /хувиар/



Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 3.4 хувьд хүрч өмнөх оноос 0.6 пунктээр буурсан 482 ББСБ-ын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү үзүүлэлттэй байна.

Зураг 22. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Нийт эх үүсвэр: Нийт пассив өмнөх оноос 315.7 тэрбум төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн байна. Үүний 307.4 тэрбум төгрөг буюу 23.9 хувийг нийт өр төлбөр, 977.4 тэрбум төгрөг буюу 76.1 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Мөн 57.7 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 17.5 хувийг хуримтлагдсан ашиг, 11.8 хувийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 4.5 хувийг

итгэлцлийн үйлчилгээний өглөг, үлдсэн хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна. Өөрийн хөрөнгө 219.2 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар нэмэгдэж 977.4 тэрбум төгрөгт хүрэхэд хувь нийлүүлсэн хөрөнгө 145.4 тэрбум төгрөгөөр буюу 24.4 хувиар, хуримтлагдсан ашиг 69.5 тэрбум төгрөгөөр буюу 44.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 6. Пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/


№	Өр төлбөр ба эздийн өмч	2017		2018		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Нийт өр төлбөр	211.0	21.8%	307.4	23.9%	96.4	45.7
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	39.2	4.0%	57.6	4.5%	18.4	46.9
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	112.8	11.6%	151.0	11.8%	38.2	33.9
3	Бусад эх үүсвэр	6.7	0.7%	15.7	1.2%	9.0	134.3
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	6.9	0.7%	23.5	1.8%	16.6	240.6
5	Төслийн зээлийн санхүүжилт	14.8	1.5%	17.8	1.4%	3.0	20.3
6	Бусад өр төлбөр	30.6	3.2%	41.8	3.3%	11.2	36.6
Б	Өөрийн хөрөнгө	758.2	78.2%	977.4	76.1%	219.2	28.9
7	Хувьцаат капитал	595.4	61.4%	740.8	57.7%	145.4	24.4
8	Бусад өмч	6.6	0.7%	10.6	0.8%	4.0	60.6
9	Сангууд	0.4	0.0%	0.5	0.0%	0.1	25
10	Хуримтлагдсан ашиг/ алдагдал	155.1	16.0%	224.6	17.5%	69.5	44.8
11	Хоёрдогч өглөг	0.7	0.1%	1.0	0.1%	0.3	42.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		969.2	100%	1284.9	100%	315.7	32.6

Салбарын нийт орлого 2018 оны жилийн эцэст өмнөх оноос 32.5 хувиар өсөж 259.5 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт орлогын 83.8 хувийг хүүгийн орлого, 12.9 хувийг хүүгийн бус орлого, 3.3 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлж байна.

Нийт зардал өмнөх оноос 22.7 хувиар өсөж 158.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хүүгийн зардал 44.7 хувиар, хүүгийн бус зардал 21.1 хувиар, орлогын татварын зардал 55.1 хувиар тус тус өссөн байна. Харин болзошгүй эрсдэлийн зардал өмнөх оны мөн үеэс 1.8

хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Тайлант хугацаанд 101.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оноос 34.3 тэрбум төгрөгөөр буюу 51.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 23. Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/




1.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын болон гишүүдийн тоо: Тайлант онд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын тоо 279 болж өмнөх оноос 11-ээр буурсан байна. Үүнээс Улаанбаатар хотод 176, хөдөө орон нутагт 103 ХЗХ тус тус үйл ажиллагаа эрхэлж байна. ХЗХ нь гишүүддээ төслийн санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх үйлчилгээ, санхүүгийн түрээсийн

үйлчилгээ, даатгалын төлөөлөгчийн үйлчилгээ зэрэг санхүүгийн бусад үйлчилгээг нэмэлт зөвшөөрөл, зохицуулалтын хүрээнд хүргэж үйлчилдэг. Төслийн санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх үйлчилгээг 113 ХЗХ, санхүүгийн түрээсийн үйлчилгээг 3 ХЗХ, даатгалын төлөөлөгчийн үйлчилгээг 3 ХЗХ эрхэлж байна.

Зураг 24. ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо



Газар зүйн байршлаар орон нутгийн ХЗХ-дын 37.9 хувь нь баруун бүсэд, 9.7 хувь нь зүүн бүсэд, 29.1 хувь нь хангайн бүсэд, үлдсэн 23.3 хувь нь төвийн бүсэд үйл

ажиллагаа эрхэлж байгаа бол Улаанбаатар хотын 176 ХЗХ-ны 91.5 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 8.5 хувь нь алслагдмал гурван дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7. ХЗХ-дын тархалт /бүсээр/

Байршил	2017	2018	Өөрчлөлт	
	ХЗХ-ны тоо	ХЗХ-ны тоо	Дүн	Хувь
Баруун бүс	32	39	7	21.9
Зүүн бүс	13	10	(3)	(23.1)
Хангайн бүс	29	30	1	3.4
Төвийн бүс	24	24	-	-
Төвийн дүүрэг	177	161	(16)	(9.0)
Алслагдмал дүүрэг	15	15	-	-


Гишүүдийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад 12.5 хувиар буюу 6,932-оор нэмэгдэж 62,556-д хүрснээс 55.9 хувь нь эмэгтэй гишүүд байна. ХЗХ-ны салбарын

тоо өнгөрсөн оноос 5-аар нэмэгдэж 27-д хүрэхэд орон нутгийн салбар нэгжийн 33 хувийн өсөлт нөлөөллөө.

Хүснэгт 8. ХЗХ-дын тоо, гишүүдийн үзүүлэлт /хүйс, байршлаар/

№	Үзүүлэлтүүд	2017	2018	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
1	Нийт ХЗХ-ны тоо	290	279	(11)	(4)
	Үүнээс: хөдөө орон нутаг	98	103	5	5
2	Нийт гишүүдийн тоо	55,624	62,556	6,932	12.5
	Үүнээс: эмэгтэй	31,968	34,984	3,016	9
	Үүнээс: эрэгтэй	23,235	27,450	4,215	18
	Үүнээс: хуулийн этгээд	421	122	(299)	(71)
4	Нийт ажиллагсдын тоо	745	796	44	6
	Үүнээс: эмэгтэй	541	603	62	11
5	Нийт салбар нэгжийн тоо	22	27	5	23
	Үүнээс: Улаанбаатар хотод	7	7	-	-
	Үүнээс: хөдөө орон нутаг	15	20	5	33


Зураг 25. ХЗХ-дын тархалт /газарзүйн байршлаар/



Хөрөнгийн үзүүлэлт: Тайлант онд хадгаламж, зээлийн хоршоод нийт 200.2 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажилласан ба энэ нь өмнөх оноос 30.7 хувиар өссөн

үзүүлэлт юм. Энэхүү өсөлтийн 60.6 хувийг зээлийн өсөлт дангаар бүрдүүлсэн байна.


Зураг 26. ХЗХ-дын нийт хөрөнгө, өсөлт



Хадгаламж, зээлийн хоршоодыг хөрөнгийн бүлгээр нь ангилан нийт хөрөнгөд эзлэх хувийг тооцвол, салбарын нийт хөрөнгийн 83.4 хувийг нэг тэрбум төгрөгөөс дээш

хөрөнгөтэй 21 ХЗХ, 13.1 хувийг 100 саяас нэг тэрбум хөрөнгөтэй 123 ХЗХ, үлдсэн буюу 3.5 хувийг 100 саяас доош хөрөнгөтэй 135 ХЗХ-д бүрдүүлж байна.

Зураг 27. ХЗХ-дын нийт хөрөнгөд эзлэх хувь /хөрөнгийн бүлгээр/




Зээлийн үзүүлэлт: Салбарын хувьд 3.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулж нийт 130.2 тэрбум төгрөгийн цэвэр зээлтэй байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өнгөрсөн оноос 0.3 пунктээр өсөж 4.5 хувьд хүрч нийт чанаргүй зээлийн хэмжээ 6.0 тэрбум

төгрөгийн дүнтэй байна.

Нийт зээлийн үлдэгдэл өнгөрсөн онтой харьцуулахад 27.2 хувиар буюу 28.6 тэрбум төгрөгөөр өсөж 133.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Зураг 28. ХЗХ-дын нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/



Хэвийн зээл өнгөрсөн оноос 28.9 хувиар буюу 27.7 тэрбум төгрөгөөр өсөж 123.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн ангилал дахь муу зээлийн эзлэх хувь өнгөрсөн оноос 17.4 пунктээр буурч 21.2 хувь


болсон байна. Харин хэвийн бус зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь өнгөрсөн оноос 6.8 пунктээр буурч 18.7 хувь болсон бол эргэлзээтэй зээлийн эзлэх хувь 24.2 пунктээр өсөж 60.0 хувьд хүрсэн байна.

Зураг 29. ХЗХ-дын чанаргүй зээлийн үзүүлэлт /эзлэх хувиар/




Хадгаламжийн үзүүлэлт: Салбарын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 42.5 хувийн өсөлттэй байгаа бөгөөд түүний 98.3 хувийг хугацаатай хадгаламж, 1.7 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 30. ХЗХ-дын нийт хадгаламж, өсөлт




Тайлант онд ХЗХ-дын 90.7 хувь буюу 253 ХЗХ нь нийт 141.5 тэрбум төгрөгийн хадгаламжтай ба үлдсэн 9.3 хувь буюу 26 ХЗХ нь огт хадгаламж татаагүй байна. Хадгаламжийн хэмжээгээр бүлэг болгон нийт хадгаламжид эзлэх хувийг авч үзвэл, 1 тэрбумаас дээш төгрөгийн хадгаламжтай 15 ХЗХ нь нийт 124.4 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 87.9

хувийг, 100 саяас 1 тэрбум төгрөгийн хадгаламжтай 46 ХЗХ нь нийт 12.4 тэрбум төгрөг буюу салбарын нийт хадгаламжийн 8.7 хувийг эзэлж байна. Харин 10 саяас 100 сая төгрөгийн хадгаламжтай ХЗХ-д 134 байгаа ба эдгээр нь салбарын нийт хадгаламжийн 3.2 хувийг эзэлж байна.



Ашигт ажиллагаа: Тайлант онд нийт ХЗХ-д 41.2 тэрбум төгрөгийн орлого, 35.9 тэрбум төгрөгийн зардал, 5.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Харин цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь өмнөх оноос 4 пунктээр буурч 12.9 хувьд хүрчээ. Салбарын хэмжээнд нийт 279


ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 198 ХЗХ нь 5.6 тэрбум төгрөгийн ашигтай, 73 ХЗХ 0.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 8 ХЗХ үйл ажиллагаа явуулаагүй байна.



Нийт орлого өмнөх оноос 29.6 хувиар өсөж 41.2 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт зарлага 36.5 хувиар өсөж 35.9 тэрбум төгрөгт хүрчээ. Эндээс салбарын нийт цэвэр ашиг 5.3 тэрбум төгрөгт хүрснээр өнгөрсөн онтой харьцуулахад 3.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү цэвэр ашгийн бууралтад санхүүгийн түрээсийн

хүүгийн зардлын 2.6 дахин өсөлт, болзошгүй эрсдэлийн сангийн зардлын 1.7 дахин өсөлт, ажилтнуудад олгосон нөхөн олговрын зардлын 11.4 дахин өсөлт, торгуулийн зардлын 7.2 дахин өсөлт зэрэг зардлын өндөр өсөлтүүд нөлөөлжээ.

Зураг 33. ХЗХ-дын ашигт ажиллагааны өсөлт /хувиар/



ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ


Хорооны 2016 оны 261 дүгээр тогтоолоор баталсан бүтцээр салбарыг тодорхойлох газрууд нь бодлого зохицуулалт, бүртгэл зөвшөөрлийн гэсэн чиг үүрэгтэйгээр зохицуулалттай байгууллагуудын тогтвортой хөгжих боломж, стандартыг нь сайжруулан нэгдсэн бодлогоор дэмжин ажиллаж байна.

2.1. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Хороо нь санхүүгийн салбарт үнэт цаасны зах зээл, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо гэсэн салбаруудыг Монгол Улсын 23 хууль тогтоомж 160 гаруй дүрэм журмын хүрээнд зохицуулалтыг хийж байна.

Тайлант хугацаанд захиргааны ерөнхий хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Хорооноос баталсан журам, дүрэм, заавар, маягтуудыг тус хуульд нийцүүлэн холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах, хүчингүй болгох зэрэг сайжруулан, нэгтгэн ХЗДХЯ-аар батлуулсан явдал байлаа.

Мөн санхүүгийн салбарт дэвшилтэт технологийн хөгжил хурдацтай өөрчлөгдөж байгаа тул түүнд оролцогч талуудын хувьд уламжлалт бизнесийн загвараас шинэ инновацлаг загвар луу шилжихтэй холбоотой зохицуулалтын арга, хэлбэрийг судалж зах зээлийг дэмжсэн тогтвортой бодлогыг барьж ажиллахыг эрмэлзэж байна.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ:

Шинээр боловсруулагдаж буй болон нэмэлт, өөрчлөлт оруулж буй дараах хуулийн төсөл, журмуудад санал өгч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллалаа. Үүнд :

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-295 дугаар тушаалаар байгуулагдсан “ОУВС-ын Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах шаардлагын хүрээнд банкны тогтолцоог тогтворжуулах, өөрийн хөрөнгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т ажилласан. Тус хуулийн төслийг УИХ-аас 2018 онд “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль” нэртэйгээр баталсан.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүд боловсруулагдаж байгаатай холбогдуулан хөрөнгийн зах зээлийн нийлүүлэлтийг дэмжих, шинээр үнэт цаас гарган нээлттэй болж байгаа хуулийн этгээдийн хувьцаа, өрийн хэрэгслийг Арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн өдрөөс нь эхлэн тодорхой хугацаанд татвараас чөлөөлөх, хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдаж буй компанийн өрийн хэрэгсэл /бонд/-ийн хүү, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг татвараас чөлөөлөх зэрэг асуудлаар хамтран санал боловсруулсан.

- Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон Валютын зохицуулалтын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдэд ажиллаж, олон улсын жишгийг судалж, холбогдох саналыг боловсруулсан.
- Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байгаатай холбогдуулан санхүүгийн салбарт нэгдсэн хяналт, зохицуулалтыг бий болгож, мөрдүүлэх саналыг боловсруулсан.

Үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, оновчтой, үр дүн бүхий бодлого, зохицуулалтын орчинг бий болгох хүрээнд журмын төслүүдийг танилцуулгын хамт боловсруулж, салбарын оролцогчдын дунд хэлэлцүүлж, гарсан саналыг судалж, улмаар журмын төслүүдийг шинэчлэн боловсруулах, батлуулах, бүртгүүлэх ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын Их Хурлаас 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт “Зохицуулалттай зах зээл дэх үнэт цаасыг барьцаалахтай холбогдсон харилцааг энэ хуульд үндэслэн үнэт цаасыг зохицуулах, хянах эрх бүхий байгууллагын тогтоосон журмаар зохицуулна” гэж заасны дагуу “Үнэт цаас барьцаалах тухай журам”-ын төслийг боловсруулж, Хорооны 2018 оны 382 дугаар тогтоолоор “Үнэт цаас барьцаалах тухай журам” нэртэйгээр баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлээ.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг Хорооноос баталсан багц дүрмээр зохицуулна” гэж заасан байдаг ба 26.2 дахь хэсэгт зааснаар энэхүү багц дүрэм нь нийт 14 дүрэм, журам, аргачлал, заавраас бүрдэх юм. Иймд тус багц дүрмийг боловсруулах хүрээнд дээрх 14 харилцааг нэгтгэн 5 журам болгон багцаллаа.

Мөн Хорооны 2014 оны 373 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар”-ын дагуу арилжаа эрхлэх, төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагын дүрэм, журмыг бүртгэх, батламжлах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Хорооны даргын 2018 оны 68 дугаар тушаалаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Арилжааны журам”, “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”, “Үнэт цаасны бүртгэлийн журам”;
- Хорооны даргын 2018 оны 452 дугаар тушаалаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Гишүүнчлэлийн журам”;
- Хорооны даргын 456 дугаар тушаалаар “Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн “Гишүүнчлэлийн журам”, “Арилжааны журам”, “Тооцооны үйл ажиллагааны журам”, “Бүртгэлийн журам”;
- Хорооны даргын 619 дүгээр тушаалаар “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ТББ-ын “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны дүрэм”, “Үнэт цаасны зах зээлд хориглосон үйл ажиллагааг явуулахаас урьдчилан сэргийлэх журам”, “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүнчлэлийн журам”, “Монголын үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх эрх авсан мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм, мэргэжлийн үйл ажиллагааны стандарт”, “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдлага, зохион байгуулалт,

үйл ажиллагааны журам”, “Гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих болон гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам”, “Мэргэшлийн сургалт зохион байгуулах, давтан сургах болон мэргэжилтэнд эрх олгох журам”;

- Хорооны даргын 2018 оны 649 дүгээр тушаалаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ыг тус тус батламжилсан.



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ:

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хуралд “Даатгалын салбарын өнөөгийн байдал, стратеги, тулгамдаж буй асуудал”-ын талаар танилцуулга хийсэн. Тус хурлаар “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажиллах талаар хэлэлцэн шийдвэрлүүлсэн.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 86/313 тоот хамтарсан тушаалаар Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн гишүүд хуулийн төсөл боловсруулах тандан судалгаа болон үзэл баримтлалыг боловсруулж дууссан.

“Хувийн тэтгэврийн даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулахаар АХБ, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарсан 4 талт санамж бичгийг байгуулан ажиллаж байна.

Банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөгдөх дараах журмуудыг боловсруулж батлуулах, эрх бүхий байгууллагад хянуулж бүртгүүлэх ажлын хүрээнд 7 журам, заавар, нөхцөл шаардлагыг шинээр баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн ХЗДХЯ-нд бүртгүүллээ. Үүнд:

- Хорооны 2018 оны 207 дугаар тогтоолоор баталсан “Сайн дурын даатгалын хэлбэр”;
- Хорооны 2018 оны 208 дугаар тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”;
- Хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”;
- Хорооны 2018 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”;
- Хорооны 2018 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар”;
- Хорооны 2018 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”;
- Хорооны 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Жолоочийн хариуцлагын албан

журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид хуваарилах журам”-ыг тус тус бүртгүүлсэн.

“Даатгалын багц дүрэм”-ийн төслийг боловсруулан **Захиргааны ерөнхий хуулийн** дагуу даатгалын зах зээлд оролцогчид, мэргэжлийн холбоод болон олон нийтээс саналыг авч, хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам”, “Даатгагч өөрийн эрсдэл ба төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын төслийг тус тус боловсруулж, Ажлын албаны даргын 2018 оны 290 дугаар тушаалаар баталсан.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА:

Шинээр боловсруулж байгаа болон нэмэлт, өөрчлөлт оруулж буй дараах хуулийн төсөл, журмуудад санал өгч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллалаа. Үүнд:

- Банкны тухай хууль, Валют зохицуулалтын тухай хууль, Шуудангийн тухай хууль, Санхүүгийн түрээсийн тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, саналаа хүргүүлсэн ба Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт УИХ-аар батлагдаж, Валют зохицуулалтын тухай хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж байна.
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, төслийн үзэл баримтлал, хуулийг шинэчлэн боловсруулах талаарх тандалтын судалгаа, шинэчлэн боловсруулсан хуулийн төслийн үр нөлөө болон зардлын судалгаа, хуулийн төслийн танилцуулгыг эцэслэн боловсруулж, Дэлхийн банкны дотоод зөвлөхүүдийн саналыг тусган ажиллав. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд олон улсын гадаад зөвлөх хуулийн төсөл дээр ажиллуулахаар харилцан тохиролцоод зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлэв.

Салбарын зохицуулалтын орчинг боловсронгуй болгох хүрээнд журмын төслүүдийг боловсруулж, салбарын оролцогчдын дунд хэлэлцүүлж, гарсан саналыг нэгтгэн танилцуулгыг боловсруулж ажиллалаа. Үүнд:

- Гадаад валютын арилжааг дагнан эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын зохицуулалтын журмын төслийг шинэчлэн боловсруулж, улмаар Валют зохицуулалтын тухай хуулийн төслийн нэмэлт өөрчлөлт батлагдсаны дараа журмын төслийг дахин авч үзэхээр тогтсон.
- “ЗБДС-ийн үйл ажиллагааны зохицуулалт, хяналт тавих журам”-ын төслийг боловсруулж, танилцуулга, судалгаа хийж, Сангийн яам /СЯ/, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-аас санал авсан. “ЗБДС-ийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын төслийг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ЗБДС-ийн удирдлагад танилцуулж, журмын төсөлд санал авахаар хүргүүлж хэлэлцүүлэг хийгээд Хорооны хурлаар батлахаар ажиллаж байна.
- Банкнаас бусад санхүүгийн салбарын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, санхүүгийн зах зээлийн оролцогчдод зориулсан сургалтын хөтөлбөрт ёс зүй, хэм хэмжээ төлөвшүүлэх сэдвийг оруулах төлөвлөгөөт ажлын хүрээнд гадаад улс орны банк болон бичил санхүүгийн салбарын ёс зүйн кодексын

тухай судалгааг хийж, салбарын оролцогч байгууллагын ёс зүйн дүрмийн төслийг боловсруулан “Санхүүгийн салбарын комплаенс-2018” форумар хэлэлцүүлэн баталж, “ББСБ-ын удирдлагыг сертификатжуулах” сургалтын хөтөлбөрт “ББСБ-ын ажилчдын ёс зүй” сэдвийг нэмж ажиллалаа

Санхүүгийн салбарт мөрдөгдөх дараах журмуудыг боловсруулж батлуулах, эрх бүхий байгууллагад хянуулж бүртгүүлэх ажлын хүрээнд 4 тогтоол шийдвэрт нөлөөллийн шинжилгээ хийж, Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн ХЗДХЯ-нд бүртгүүлсэн. Үүнд:

- Хорооны 2016 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх”,
- 2017 оны 90, 91 дүгээр тогтоол “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” зэргийг тус тус бүртгүүлсэн.



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО:

“Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т хадгаламж, зээлийн хоршооны салбарт тогтворжилтын сангийн үйл ажиллагаа, хадгаламжийн даатгалын тогтолцоо, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх зорилт туссаны дагуу дараах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хадгаламж, зээлийн хоршооны салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэхээр зайны хяналтын журам, эрсдэлийн үнэлгээ хийх гарын авлагын төслийг боловсруулсан. Зайны хяналтын журмын төслийн дагуу хадгаламж, зээлийн хоршоодын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үнэлгээ хийж аргачлалыг туршсан. Эрсдэлийг тооцоход зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг суурь болгон нийт хадгаламж, зээлийн хоршоодыг эрсдэлийн түвшингээр 5 ангилан хувааж, хамгийн өндөр эрсдэл бүхий хадгаламж, зээлийн хоршоодод авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Эрсдэлийн үнэлгээг хадгаламж, зээлийн хоршоодын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тулгуурлан давтах бөгөөд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг газар дээрх шалгалтаар харьцуулах арга хэмжээ авахаар төлөвлөж байна.
- Хадгаламж, зээлийн хоршоодод мөрдүүлж байгаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн нийцтэй байдлыг сүүлийн 12 улирлын байдлаарх тоон мэдээлэлд тулгуурлан үнэлсэн.
- Хадгаламж, зээлийн хоршоодын зээлийн шимтгэлийн болон хоршооны гишүүдийн даатгагдах хадгаламжийн оновчтой түвшинг тодорхойлоход чиглэсэн хадгаламжийн судалгаа хийсэн.
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг салбарын оролцогчдын төлөөллийг оролцуулан байгуулсан бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ зэрэг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг хийж, салбарын хөгжлийг дэмжих зохицуулалт болох санхүүгийн дундын байгууллагыг байгуулах, тогтворжилтын сангийн болон гишүүдийн хадгаламж хамгааллын тогтолцоог

бүрдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг нарийвчлан тусгах байдлаар хуулийн төслийг боловсруулсан.

АХБ–наас хэрэгжүүлж буй “Хадгаламж, зээлийн хоршооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих төсөл”–ийн хүрээнд хийгдсэн ажлыг үргэлжлүүлэхээр төслийн саналыг боловсруулсан. Төслийн 2 дахь шат 2019 оноос бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах чиглэлд хэрэгжихээр болж Хороо, АХБ–тай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.

Татварын багц хуулийн төслийг хэлэлцүүлж байгаатай холбогдуулан хадгаламж, зээлийн хоршоо нь ашгийн төлөө бус байгууллага тул аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх, түүнчлэн хадгаламжийн хүүгийн орлогын албан татвараас хоршооны гишүүдийн 5 хүртэлх сая төгрөгийн хадгаламжийг чөлөөлөх тухай саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.

УБЕГ–ын хадгаламж, зээлийн хоршооны улсын бүртгэлийг Хорооны тусгай зөвшөөрлийн бүртгэлтэй тулгаж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл Хорооноос аваагүй, авсан ч хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаагүй зэрэг зөрчлийн улмаас тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон боловч хуулийн этгээдийн улсын бүртгэлд хадгаламж, зээлийн хоршоо хэлбэрээр бүртгэлтэй 183 хуулийн этгээдийн мэдээллийг шүүн гаргасан. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй атал улсын бүртгэлд бүртгэгдсэн хадгаламж, зээлийн хоршоодыг татан буулгах, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах ажлын бэлтгэлийг хангасан.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт нэвтрүүлэх боломжтой технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний судалгаа хийх хүрээнд Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос Тайланд, Филиппин улсуудад нэвтрүүлж буй төлбөр тооцооны КАҮА системийн талаар судалсан.

Хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор баталсан "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам"–ын хавсралт болох үнэлгээний аргачлалын дагуу 9 хадгаламж, зээлийн хоршооны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийж буй үйл ажиллагааг дүгнэсэн. Хадгаламж, зээлийн хоршоодын 2 нь бага эрсдэлтэй байсан бол 4 нь дунд эрсдэлтэй, 3 нь өндөр эрсдэлтэй байна.

2.2. БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхий хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлаар Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар хамтын шийдвэрүүдийг эцэслэн гаргадаг. Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар гаргасан шийдвэрүүдийг салбаруудаар харуулбал:

Үнэт цаасны зах зээл: Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг 4, брокер, дилер, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх 5 (давхардсан тоогоор), хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 компанид олгосон байна.

Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай 7, нэмж гаргах энгийн хувьцааг бүртгэх тухай 1, нийтэд

санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх тухай 1, хаалттай хүрээнд гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай 1, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх тухай 3, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай 5, дүрэмд өөрчлөлт оруулах тухай 1 компанийн хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн байна.

Үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх 5 компани, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх 5 нөхөрлөл, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 2 компанийг тус тус бүртгэсэн байна.

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх 2 компанийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байна.

Хүснэгт 9. Зөвшөөрлийн тоо /Үнэт цаасны зах зээл/

№	Зөвшөөрлийн нэр	Тоо
1	Оноосон нэр өөрчлөх	4
2	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	18
3	Гүйцэтгэх захирал шинээр томилох	13
4	Салбарын зөвшөөрөл олгох	2

Даатгалын зах зээл: Даатгалын зах зээлийн чиглэлээр 8 компанид даатгалын зуучлагчийн, 1 компанид даатгалын хохирол үнэлэгчийн, 52 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг

олгож, даатгалын зуучлагч 2 компани, даатгалын хохирол үнэлэгч 4 компани, даатгалын төлөөлөгч 514 иргэний тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болголоо.

Хүснэгт 10. Зөвшөөрөл, эрхийн тоо /Даатгалын зах зээл/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Оноосон нэр өөрчлөх	3
2	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	19
3	Салбарын зөвшөөрөл олгох	98
4	Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл олгох	54
5	Актуарчийн эрх олгох	8
6	Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх	102
7	Хаяг байршлыг өөрчлөх	23
8	Даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгэх	20

Банк бус санхүүгийн байгууллага: Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 15 компанид шинээр олгож, 11 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон, 22 ББСБ-ын

үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 7 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж дараах зөвшөөрөл, эрхийг бүртгэжээ.

Хүснэгт 11. Зөвшөөрлийн тоо /ББСБ/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Оноосон нэр өөрчлөх	10
2	Нэмэлт тусгай зөвшөөрөл олгох	27
3	Салбарын зөвшөөрөл олгох	32
4	Салбар хаах	1
5	Төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгох	1
6	Хаяг байршлыг өөрчлөх	89
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	372
8	Гүйцэтгэх захирлын өөрчлөх	93

Хадгаламж, зээлийн хоршоо: Нийт 18 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, 19 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээж, 29

ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон, 100 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг шийдвэрлэсэн ба дараах зөвшөөрлийг олгож, өөрчлөлтийг бүртгэсэн байна.

Хүснэгт 12. Зөвшөөрлийн тоо /ХЗХ/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Төслийн санхүүжилтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох	1
2	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох	1
3	Салбарын зөвшөөрөл олгох	5
4	Хаяг байршлыг өөрчлөх	25
5	Гүйцэтгэх захирал, сонгуульт гишүүдийн өөрчлөлтийг бүртгэх	68

2.3. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

Хяналт, шалгалтыг Хорооны зохицуулалттай этгээдүүд болох нийт 305 ХК, 54 ҮЦК, 12 ХААБ, үнэт цаасны арилжаа эрхлэх 2 байгууллага, 1 хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж, 2 өөрийгөө зохицуулах байгууллага /"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо/, 1 үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага, 1 төвлөрсөн хадгаламжийн байгууллага, 3 кастодиан банк, 17 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 12 хөрөнгө оруулалтын сан, 3 хөрөнгө итгэмжлэн удирдах компани, 18 тусгай зориулалтын компани, 23 үнэлгээний компани, 26 хуулийн компани,

15 ердийн даатгагч, 1 урт хугацааны даатгагч, 2 давхар даатгагч, 49 даатгалын зуучлагч, 27 даатгалын хохирол үнэлэгч компани, 539 ББСБ, 279 ХЗХ зэрэг нийт 2,347 зохицуулалттай этгээдийн санхүү, төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд зайнаас болон газар дээрх хяналт, шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хуульд заасан арга хэмжээг авах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиг үүргээ Хорооны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлээ.

Давхардсан тоогоор нийт 9,314 сарын болон улирлын санхүүгийн тайланд зайны хяналтыг, 1,089 зохицуулалттай этгээдэд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар дараах нийтлэг зөрчил, дутагдлууд илэрсэнд зөвлөмж, санхүүгийн тайлангийн хариу болон улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Хороонд бүртгэлтэй ажлын байранд үйл ажиллагаа явуулаагүй, ажлын байргүй, хаягийн өөрчлөлтийг Хороонд бүртгүүлээгүй;
- ББСБ–д нягтлан бодох бүртгэлийн програмгүй;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ерөнхий болон нэмэлт нөхцөл, шаардлагыг хангаагүй;
- Хорооноос зөвшөөрсөн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан;
- Даатгалын төлөөлөгч, зуучлагчийн тусгай зөвшөөрөлгүй, эрхгүй этгээдэд даатгалын орлогын шимтгэл өгсөн;
- Зарим даатгалын тохиолдлуудад даатгалын гэрээнд заагдаагүй нөхцөлөөр даатгалын нөхөн төлбөрийг бууруулж олгосон, мөн хохирол үнэлэгчийн тогтоосон хохирлын үнэлгээг өөрсдийн тооцооллоор бууруулсан;
- Зарим ББСБ болон хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаагүй;
- Зээлийн эрсдэлээс хамгаалах санг дутуу байгуулсан;

- Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, Монголбанкны зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулж хамтран ажиллаагүй;

Мөн зохицуулалттай этгээдийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, торгууль шийтгэлийн орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэхэд байнгын хяналт тавьж ажиллав.

Зайны хяналт, шалгалт: Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, тусгай зөвшөөрлийн бусад нөхцөл шаардлагыг хангуулахаар давхардсан тоогоор нийт 9,314 сарын мэдээ болон улирал бүрийн санхүүгийн тайланд зайны хяналтыг хэрэгжүүлсэн.

Мөн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр нийт 124 ХК–ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хянаж, холбогдох хариуг хүргүүлсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулаагүй нэр бүхий 55 ХК–ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн уг хурлыг зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болсон талаарх мэдээллийг Хорооны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэв.

Зайны хяналтын үр дүнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн тайлангийн хариугаар үүрэг даалгавар өгч, Улсын байцаагчийн нийт 54 албан шаардлагыг холбогдох зохицуулалтын байгууллагуудад хүргүүлж, биелэлтийг нь хангуулан ажилласан.

Газар дээрх хяналт, шалгалт: Нийт 1,089 зохицуулалттай этгээдийг газар дээрх хяналт шалгалтад хамруулсан ба үүний 1,018 нь үзлэг болон төрөлжсөн хяналт шалгалтад, 54 нь хэсэгчилсэн, 17 нь иж бүрэн хяналт шалгалтад хамрагдсан.

Хүснэгт 13. Хяналт шалгалтад хамрагдсан зохицуулалттай этгээдийн тоо		
Зохицуулалттай этгээд	2017	2018
Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд	37	79
Даатгалын байгууллага	67	212
Банк бус санхүүгийн байгууллага болон хуулийн этгээд	110	557
Хадгаламж, зээлийн хоршоо	29	241
НИЙТ	243	1,089

Газар дээрх хяналт, шалгалтад хамрагдсан зохицуулалттай этгээдийн нийт тоо өмнөх оноос 4.5 дахин

өсөхөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын

хүрээнд 1,018 хуулийн этгээдэд үзлэг болон төрөлжсөн хяналт шалгалт хийгдсэн нь голлон нөлөөлжээ.

Үнэт цаасны хяналтын чиглэлээр: Үнэт цаасаа нийтэд санал болгон гаргасан нэр бүхий 3 ХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад газар дээрх хяналт шалгалтыг хийв.

Даатгалын хяналтын чиглэлээр: Нэр бүхий 6 даатгалын компанийн үйл ажиллагаанд иж бүрэн газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэв.

ББСБ-ын хяналтын чиглэлээр: Иж бүрэн шалгалтад 2 ББСБ, хэсэгчилсэн шалгалтад 44 ББСБ хамрагдав.

ХЗХ-ны хяналтын чиглэлээр: Нийслэл болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 6 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх иж бүрэн хяналт шалгалтыг, хадгаламж зээлийн хоршооны салбарт хамгийн өндөр актив хөрөнгөтэй нэр бүхий 10 ХЗХ-нд хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэв.

Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх чиглэлээр: Гомдол, мэдээллээр илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 18 зохицуулалттай этгээдэд 365.6 сая төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, 144.9 сая төгрөгийн биелэлтийг хангуулж, үлдсэн нь шүүхийн шатанд хянагдаж байна.

Тусгай зөвшөөрөл: Зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүнд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг нь хангуулан ажилласан ба үйл ажиллагаа нь доголдсон, холбогдох хууль тогтоомжийг биелүүлээгүй 52 зохицуулалтын этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан учир 22 этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээх, 57 этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 1 этгээдийн тусгай зөвшөөрлийг сунгах, 2 ХК-ын нийтэд санал болгосон үнэт цаасыг бүртгэлээс хасах асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ.

2.4. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний

хөтөлбөр”, мөн 327 дугаар тогтоолоор батлагдсан “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”, Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагын /ФАТФ/ Техникийн хэрэгжилтийн үнэлгээний 40 зөвлөмж зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Хороо 2018 онд дараах голлох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон Терроризмтой тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсгүүдэд хамтран ажилласан.
- Хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг баталсан.
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн зохицуулалтуудыг салбар бүрийн онцлогт нийцүүлэн “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, “Даатгалын багц дүрэм”, “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага” зэрэг эрх зүйн актуудад тусгасан.
- Хорооны даргын 2018 оны 627 дугаар тушаалаар “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлдэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны улирлын тайлан, мэдээний загвар”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний аргачлал”, “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тоон болон чанарын өгөгдөл цуглуулах маягт”, “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга”, “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матриц”-ийг тус тус баталсан.
- Хорооны даргын 2018 оны 640 дүгээр тушаалаар

үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаатай холбогдон үүссэн харилцааг зохицуулах хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсруулах хоёр ажлын хэсгийг Монголбанк, Санхүү мэдээллийн алба, Сангийн яам, ХЗДХЯ, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

– Сургалт зохион байгуулах чиглэлээр: АХБ, ОУХОБ зэрэг олон улсын байгууллагуудтай хамтарсан төслүүдийн хүрээнд болон Хорооны дотоод нөөц бололцоог ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Хороо болон зохицуулалтын хүрээний байгууллагуудын 1,000 гаруй ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж 30 гаруй сургалтыг орон даяар үе шаттайгаар зохион байгуулсан.



– Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон нийтэд мэдээлэл, сурталчилгаа явуулах чиглэлээр: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гарын авлага боловсруулж зохицуулалттай этгээдүүдэд хүргэсэн. Гарын авлагад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаарх ойлголт, хууль эрх зүйн орчин, комплаенсын үйл ажиллагаа, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, эрсдэлийн удирдлага зэрэг сэдвүүдийн хүрээнд тодорхой ойлголтуудыг нарийвчлан тусгасан.

Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах зорилгоор гурван

төрлийн зурагт хуудас, товхимлыг хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын иргэдэд зориулан гаргаж тараасан.

Хорооны цахим хуудасны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх цэсийг шинэчилж, цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан олон нийтэд хүргэж ажиллав. Тус цэсэнд олон улсын хориг арга хэмжээтэй холбоотой жагсаалт, улс төрд нөлөө бүхий этгээдийн талаарх мэдээлэл, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаарх зөвлөмжүүд багтсан.

МУТСТ-тэй холбоотой хяналт, шалгалт

– Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын чиглэлээр: Зохицуулалттай байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хяналт, шалгалтын хүрээнд Олон улсын валютын сангийн зөвлөмжтэй нийцүүлэн боловсруулсан үнэлгээний асуулгын дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг байгууллага тус бүрээр хийж, “Банкнаас бусад санхүүгийн салбарын мөнгө угаах эрсдэлийн үнэлгээ-2018” нэгдсэн тайланг Монгол Улсад хийж гүйцэтгэсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарах болсноор тус салбар дахь эрсдэлийг тодорхойлох ажлын хүрээнд “Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх түүвэр судалгаа”-г Монгол Улсад анх удаа хийж гүйцэтгэсэн.

– Газар дээрх хяналт, шалгалтын чиглэлээр: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийт 1,018 хуулийн этгээд буюу 54 үнэт цаасны компани, 17 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 5 хөдөө аж ахуйн биржийн брокер, 17 даатгалын компани, даатгалын компанийн 129 салбар, 30 даатгалын зуучлагч, 23 даатгалын хохирол үнэлэгч, даатгалын хохирол үнэлэгчийн 7 салбар, 485 ББСБ, олон улсын шуудан илгээмжийн үйлчилгээ эрхэлдэг 26 хуулийн этгээд, 225 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх төрөлжсөн хяналт шалгалтыг хийв.

Хүснэгт 14. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд үзлэг болон төрөлжсөн хяналт, шалгалтад хамрагдсан зохицуулалттай этгээдийн тоо

Зохицуулалттай этгээд	2018 он
Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд	76
Даатгалын байгууллага	206
Банк бус санхүүгийн байгууллага болон бусад хуулийн этгээд	511
Хадгаламж, зээлийн хоршоо	225
НИЙТ	1,018

Тус төрөлжсөн хяналт шалгалтаар дараах нийтлэг алдаа дутагдлууд илэрсэн болно. Үүнд: МУТСТ дотоод хяналтын хөтөлбөргүй, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилоогүй, 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлдэггүй зэрэг нийтлэг алдаа дутагдлууд илэрсэн бөгөөд тухай бүр засаж залруулах зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан.

Мөн тусгай зөвшөөрөлгүй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийг илрүүлж, зөвшөөрөл өгөх болон цагдаагийн байгууллагатай хамтарч тэдний хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авах ажлын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 26 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар хууль бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж байгаа этгээд илрээгүй.

“Санхүүгийн салбарын комплаенс–2018” форум

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд Хорооноос зохион байгуулсан “Санхүүгийн салбарын комплаенс–2018” форумд Хорооны зохицуулалтын салбарын мэргэжлийн холбоод болон Үл хөдлөх хөрөнгө зуучлалын нэгдсэн холбоо, тэдгээрийн гишүүн байгууллагууд, мөн Дэлхийн банк, Олон улсын валютын сан, АХБ–ны суурин төлөөлөгч зэрэг байгууллагуудаас нийт 250 гаруй зочид төлөөлөгчид оролцсон. МУТСТ чиглэлээр салбар бүрийн хувьд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн боломжит шийдлүүдийн талаар хэлэлцсэн.

Тус форумын хүрээнд 5 салбар хуралдаан болсон бөгөөд салбар хуралдаануудаас хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, МУТСТ чиглэлээр салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэж, чадавхжуулах, мэдээллийн нэгдсэн сан бий болгох, програм хангамж, дэд бүтцийг сайжруулах зэрэг нэгдсэн болон салбар бүрийн онцлогоос хамаарсан тусгайлсан зөвлөмжийг гаргасан.



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

3.1. САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Санхүүгийн үйлчилгээг хямд өртгөөр хүргэх таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний нэгжийн өртгийг бууруулах, шинэ технологийн хэрэглээг бий болгох бодлогыг боловсруулах, тогтвортой, бүрэн, хүртээмжтэй санхүүгийн салбарыг бий болгох зорилгыг хангах зохицуулалтын бүтцийг бий болгох, бага, дунд орлоготой иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүргэх зорилгоор үйлчлүүлэгчдийг хамгаалах, эрхээ хэрэгжүүлэх боломжийг бий болгох, мэдээлэл цуглуулах, шинжлэх замаар санхүүгийн хүртээмжийн хандлагын өөрчлөлтийг бий болгон санхүүгийн хүртээмжийн бодлогыг боловсруулах нь өнөөгийн даяаршлын чухал зорилт болж байна.

3.1.1. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн болон нийслэлийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн багш нар болон холбогдох мэргэжилтнүүдэд “Иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх сургалт” зохион байгуулагдаж байгаа ба уг үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ажиллалаа.



Тус хөтөлбөрийн хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвийн аймаг, сумд дахь багш нарт зориулсан “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” санхүүгийн мэдлэг түгээх сургагч багшид банк, санхүүгийн салбарын талаар хичээл заах үйл ажиллагаа зохион байгуулж идэвхтэй оролцлоо.

Үнэт цаасны зах зээл: Хөрөнгийн зах зээлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэхээр холбогдох байгууллагуудтай дараах байдлаар хамтарч сургалт, семинар, өдөрлөг, форум, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүнд:

- Олон нийтэд хөрөнгийн зах зээлийг таниулах хандлага, оролцоог нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн болоод шинээр нэвтэрч буй технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, үүнээс хүртэх өгөөж, хүлээх эрсдэл, хөгжлийн хандлагын талаарх шинэ санал санаачилгыг олон нийтэд хүргэх зорилготой FRC plus илтгэлийн уралдааныг санаачлан цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэж анхдугаар уралдааныг FRC plus Investment сэдвийн хүрээнд зохион байгуулсан.
- Монголын Олон Улсын Хөрөнгийн Корпораци (MICC)-ийн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран зохион байгуулсан “IPO Conference 2018” арга хэмжээнд оролцсон. Тус арга хэмжээ нь МҮХАҮТ-ын гишүүн компаниуд, ялангуяа ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд олон нийтэд нээлттэй компани болох сонирхлыг төрүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилготой ба хувьцаа гаргахад тавигдах шаардлагууд болон санхүүжилтийн боломжуудын талаар танилцуулж, санхүүгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтран ажиллах боломжийг олгох явдал байв.
- Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулж буй Компанийн засаглалын 10 дахь удаагийн форумд Санхүүгийн зохицуулах хороо

хамтран зохион байгуулагчаар ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай байгууллагууд болон компаниудыг оролцуулан зохион байгуулсан.

- Үнэт цаасны зах зээлд оролцогчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр жил бүр зохион байгуулдаг “Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх хуульч, аудитуудад зориулсан сургалт”-ыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгууллаа. Мөн “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ТББ-тай хамтран “Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах мэргэжилтэнд эрх олгох сургалт”-ыг 2 удаа зохион байгуулсан.

Даатгалын зах зээл: Хорооноос Монголын даатгалын холбоотой хамтран ажиллах гэрээ, Монголын банкны холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоотой сургалт зохион байгуулах гэрээг тус тус байгуулсан. Тус гэрээнд даатгалын зах зээлд оролцогчид, тэдгээрийн боловсон хүчнийг чадавхжуулах үүднээс сургалтын үйл ажиллагааг Холбоод мэргэжлийн түвшинд зохион байгуулж, Хороо холбогдох чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллахаар тусгасан, ба Монголын даатгалын холбоо, Монголын банкны холбоотой хамтран даатгалын төлөөлөгч, зуучлагчийн сургалтыг Улаанбаатар хотод 2 удаа, орон нутгийн 5 бүсийн 21 аймагт нийт 42 удаагийн сургалтуудыг зохион байгуулж ажилласан.

Мөн Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтыг 1 удаа, Монголын хохирол үнэлэгчдийн холбоотой хамтран даатгалын хохирол үнэлэгчийн эрх олгох сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулж, сургалтад оролцогчдоос шалгалт авч ажиллалаа.

ГООУХАН, Хүртээмжтэй даатгалын асуудлаарх харилцан мэдлэг, туршлага солилцох хүрээнд “Хүртээмжтэй даатгал болон гамшгийн эрсдэлийн удирдлага (ГЭД)-д зориулсан санхүүгийн мэдлэг олгох” сургалтыг даатгалын салбарын 60 ажилтанд, ХЗДХЯам, УЕПГ, Монголбанк, Хорооны Даатгалын газар хамтран “Зөрчлийн тухай хуулийн талаар мэдлэг, мэдээлэл олгох” сургалтыг даатгалын компанийн ажилтнуудад, даатгалын мэргэжлийн (зуучлагч, хохирол үнэлэгч, аудитор) 81 оролцогчдод тус тус зохион байгуулсан.

Банк бус санхүүгийн байгууллага: Санхүүгийн зохицуулах

хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.11-д “Тусгай зөвшөөрлөө авснаас хойш 6 сарын хугацаанд банк бус санхүүгийн байгууллагын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна” гэж заасны дагуу 2018 онд шинээр тусгай зөвшөөрөл авсан болон бусад ББСБ-уудын удирдлагуудад нийт 3 удаагийн сургалтыг МББСБХ-той хамтран зохион байгуулсан ба нийт 60 ББСБ-ын удирдлага сургалтад хамрагдав.

“Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр 2016–2021”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хорооны цахим хуудсанд нийт 28 мэдээ, мэдээллийг нийтэлсэн бол энэхүү ажлын хүрээнд МУТСТ тухай хуулийн хэрэгжилтийн талаар 24 мэдээллийг бэлтгэн олон нийтэд мэдээлсэн.

Хадгаламж, зээлийн хоршоо: 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан хадгаламж, зээлийн хоршоодын дарга, хяналтын зөвлөлийн дарга нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж “Хадгаламж, зээлийн хоршооны хууль эрх зүйн орчин”, “Хадгаламж, зээлийн хоршооны удирдлага зохион байгуулалт, дотоод хяналт” зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг хадгаламж, зээлийн хоршоодод хууль, холбогдох журам, заавар, олон улсын стандарт, хууль хэрэгжилтийн нөхцөл байдал, учирч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх болон таньж мэдэх арга замуудын талаар ойлголт өгөх сургалтыг 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран зохион байгуулсан.


2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан хадгаламж, зээлийн хоршоодод зориулсан сургалтыг зохион байгуулсан бөгөөд хоршоодод Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн ач холбогдол, хэрхэн хамтран ажиллах гэрээ байгуулах, мэдээлэл нийлүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

3.1.2. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 367 өргөдөл, гомдлыг Хороонд ирүүлсэн бөгөөд нийт өргөдлийн тоог өмнөх оны

үзүүлэлттэй харьцуулахад 20.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Зураг 34. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /салбараар/



Тайлант хугацаанд ирсэн нийт өргөдөл, гомдлын тоо үнэт цаасны зах зээлийн хувьд 61.2 хувь, ББСБ-ын үйл ажиллагааны хувьд 57.6 хувь, даатгалын салбарын хувьд 8.9 хувиар тус тус өссөн бол ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо 194.4 хувиар буурсан байна.

Үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол: 2018 онд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 108 өргөдөл, гомдол ирсэн.

Зураг 35. Үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга



Үнэт цаасны салбартай холбоотой нийт өргөдлийн 27.8 хувийг брокер, дилерийн компаниар дамжуулан эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл эзэлсэн бөгөөд үүнээс 30.0 гаруй хувийг 2006 оноос өмнө үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон нэр бүхий 7 брокер,

дилерийн компаниар дамжуулан арилжаалагджээ. Эдгээр өргөдлийн тоог өмнөх онтой харьцуулахад 41.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт 30 хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдлуудад “Улаанбаатар хивс” ХК, “Тахь ко” ХК, “Материал импекс” ХК, “АПУ” ХК,


“Дархан нэхий” ХК зэрэг компаниудын хувьцааг харилцагчийн дансанд буцаан байршуулах, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК-ийн 2005 оноос хойших хугацааны ногдол ашгийг тооцон харилцагчдад олгуулах зэрэг 5 удаагийн хугацаатай үүрэг даалгаврыг холбогдох үнэт цаасны компанид хүргүүлж, 1 иргэний хувьцааг буруутай этгээдээр буцаан байршуулуулсан бол 15 хувьцаа

зээмшигчийн өргөдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлэв.

Даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол: Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 150 өргөдөл, гомдлыг Хороонд ирүүлсэн.

Зураг 36. Даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгал
- Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
- Хөрөнгийн даатгал
- Ачаа, тээврийн даатгал



Даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлүүдээр ангилвал жолоочийн хариуцлагын албан журмын, тээврийн хэрэгслийн, орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн болон бусад даатгалын тохиолдлууд нийт гомдлын 74.0 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулвал жолоочийн хариуцлагын даатгал, орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгалтай холбоотой өргөдлийн тоо 48.9 хувь болон 29.0 хувиар тус тус буурсан бол авто тээврийн хэрэгслийн даатгал 35.4 хувиар өсжээ.


Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн өргөдлийг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, даатгуулагч

29 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 622.3 сая төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргаж, үүнээс нэр бүхий 11 иргэн, хуулийн этгээдэд нийт 133.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан ба үлдсэн нь шүүхийн шатанд шийдвэрлэгдэж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол: Тайлант хугацаанд ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 56 өргөдөл, гомдол ирсэн ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 57.6 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 37. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга


- ББСБ-ын үйлчилгээ
- Зээлийн гэрээний маргаан
- Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл
- Бусад (иргэд хоорондын гэрээний маргаан)



Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдлийн 23.2 хувийг зээлдүүлэгч нь зээлдэгчийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд тухай бүр шинэчлээгүйгээс зээлдэгчийн зээлийн ангилалд сөргөөр нөлөөлсөн нөхцөл байдал үүссэн талаарх өргөдөл эзэлж байсан ба энэхүү үзүүлэлт өмнөх оноос 6 дахин ихэсжээ.

ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдөл, гомдол: ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой нийт 53 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад, хадгаламж буцаан олгоогүй талаарх зөрчлийн гомдол мэдээлэл шинээр бүртгэгдсэнийг хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэж шийтгэл оногдуулсан бол ХЗХ-дын үйлчилгээний чанартай холбоотой өргөдөл бүртгэгдээгүй байна.

Зураг 38. ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын товч утга



Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, үүрэг даалгавар, чиглэл, мэдэгдлийг өгч ажилласан. Тайлант хугацаанд Хяналт шалгалт, зохицуулалтын

газарт нийт 367 өргөдөл, гомдол ирсэн ба үүнийг шийдвэрлэсэн хугацаагаар харуулвал:

Зураг 39. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа /хоноогоор/



Өргөдөл шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй, шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх онтой харьцуулахад 5 хоноогоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн

мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага шаардсан, оролцогч талуудын хооронд илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зөрчлийн шинжтэй өргөдлийг зөрчлийн хэрэг бүртгэлд хийх, прокурорын байгууллагаар хянуулан шийдвэрлэхтэй холбоотой байна.

3.2. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын 23 хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. Мөн зохицуулалтын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, бүртгэл, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох чиглэлээр Хорооноос баталсан 160 гаруй журам, дүрэм, заавар, аргачлалыг Хорооны тогтоолоор батлан мөрдүүлж байна. 2016 оны 07 дугаар сарын 01–нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж

эхэлсэн Захиргааны ерөнхий хуульд Хорооноос баталсан хэм хэмжээ тогтоосон актуудыг нийцүүлэн шинэчлэн батлах эрх зүйн нөхцөл байдал үүссэний дагуу Хорооны даргын 402 дугаар тушаалаар батлагдсан Ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд 2018 онд нийт 14 захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Хорооны хуралдаанаар батлан “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сан”–д бүртгүүлээд байна. Үүнд:

Хүснэгт 15. Захиргааны хэм хэмжээний акт

№	Захиргааны хэм хэмжээний актын нэр	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэсэн огноо
1	“Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”	2018.01.19
2	“Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”	2018.04.17
3	“Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах шаардлага”	2018.05.21
4	“Сайн дурын даатгалын хэлбэр”	2018.06.25
5	“Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”	2018.06.25
6	“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”	2018.06.25
7	“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”	2018.06.06
8	“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар”	2018.06.25
9	“Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх зарцуулах журам”	2018.06.25
10	“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”	2018.07.10
11	“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”	2018.07.10
12	“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид хуваарилах журам”	2018.07.10
13	“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”	2018.11.29
14	“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”	2018.12.26

2018 онд дээрх журам, заавраас гадна “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”–т Хорооны тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх, “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”–ыг шинэчлэн баталж ажиллалаа.

Мөн Санхүүгийн зах зээлийн өсөлт хөгжил, тогтвортой байдлыг хангахад бодлогоор чиглүүлж, түүнийхээ үндсэн дээр зохицуулалт хийн, холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байна. Энэхүү чиг үүргийнхээ

хэрэгжилтийг үр дүнд хүргэхийн тулд дэлхий дахины санхүүгийн хөгжлийн хандлага, алсын хараа, урт, богино хугацааны зорилго, зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ бүрнээ ажил хэрэг болгож, хэмжигдэхүйц бодит үр дүнд хүргэхээр Хорооны 2018 оны 310 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018–2021)” баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.

Санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Дэлхийн банкны Төсөв

санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн зөвлөх багтай хамтран ажиллаж Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Уг төслийн багаас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай болон түүний чиг үүрэгт хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн зөвшөөрлийн тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төсөлд Хорооноос тухай бүр санал өгч ажиллалаа.


ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.

4.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Өнгөрсөн хугацаанд Хороо нь, 2016 онд батлагдсан бүтцийн хүрээнд 7 газар, 4 хэлтэс, 2 албанд нийт 139 ажилтан, албан хаагчтайгаар ажиллаж байна. Түүнчлэн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллүүдийг тогтоосон хугацаанд Хороонд ирүүлэх, Хорооны шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, зохицуулалтын байгууллагуудад хяналт тавих үүрэг бүхий 63 орон нутгийн төлөөлөгчид Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж байна.

Зураг 40. Бүтэц



4.2. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ажлын төлөвлөлт зохион байгуулалт, дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр:

- Тайлант хугацаанд Хорооны 18 удаагийн хуралдаанаар 356 асуудлыг хэлэлцэж, 382

шийдвэр гаргажээ. Тухайлбал, санхүүгийн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, оролцогчдод тавигдах шаардлагыг өндөржүүлэх, хөрөнгө оруулагч,

үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр санхүүгийн зах зээлд дагаж мөрдөгдөх шинээр 7 журам, 1 заавар, 1 шаардлага, 1 маягт гэрээний стандарт, 1 шалгуур үзүүлэлт, 3 журам, нэмэлт өөрчлөлт оруулсан 1 зааврыг тус тус Хорооны хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

- Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 11 бодлогын баримт бичгийн 125 заалтын биелэлтийг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн.
- Шинээр буюу шинэчлэн найруулсан, өөрчлөлт оруулж баталсан Монгол Улсын хууль 162, УИХ-ын тогтоол 86, ЭЗБХ-ны тогтоол 2, Засгийн газрын тогтоол 3, Засгийн газрын албан даалгавар 1, Засгийн газрын хуралдааны 1 тэмдэглэлийг тус тус хүлээн авч, Хорооны үйл ажиллагаанд шууд хамааралтай тогтоол шийдвэрүүдэд хяналт тавин ажиллалаа.
- Хорооны даргаас 668 тушаал, Улсын Ерөнхий байцаагчаас 2 тушаал, Ажлын албаны даргаас 329 тушаал, Хорооны даргаас 2 албан даалгавар гаргаж бүрэн эрхээ хэрэгжүүлэв.
- Хорооны 2017 оны үйл ажиллагааны тайланг УИХ-д тайлагнаж, тайлан болон банкнаас бусад салбарын тоймыг олон нийт болон төрийн холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа.

Мэргэжлийн холбоод, байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл бүхий 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан Бодлогын зөвлөл 2 удаа хуралдаж, салбаруудын 2017–2018 онд хийж гүйцэтгэсэн

үйл ажиллагааны тайлан, салбаруудад тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн.

Хорооны Ажлын албаны дэргэд байнгын ажиллагаатай орон тооны бус “Баримт бичиг нягтлан шалгах комисс”, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”, “Ёс зүйн хороо” тус тус ажиллаж архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт тавьж, өмч хөрөнгө хамгаалах, албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж ажилласан байна.

Мөн төрийн санхүүгийн бодлогыг хэрэгжүүлж, санал дүгнэлт гаргах, хууль тогтоомж боловсруулах, судалгаа хийх зэрэг чиглэлээр УИХ, Засгийн газар, бусад төрийн байгууллагуудтай хамтарсан 6 ажлын хэсэгт ажиллалаа.

Архив, албан хэрэг хөтлөлт: “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Баримт бичгийн улсын стандарт”, “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын дагуу 13,449 албан бичиг, 402 өргөдөл хүлээн авч, 1,920 хариутай бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, 4,966 албан бичиг хүргүүлсэн ба нийт бичиг хэргийн эргэлт 18,817 буюу хоногийн бичиг хэргийн эргэлт 75 байв. Архивын нөхөн бүрдүүлэлт 1,836 нэгжээр нэмэгдэж, архивд 2006–2017 оны данс бүртгэлтэй 15,594 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Байгууллага, иргэдийн хүсэлтээр архиваас 5,372 хуудас баримтыг хуулбарлан олгов.

Тайлант хугацаанд албан бичгийн эргэлт өмнөх оноос 8.3 пунктээр нэмэгдэж 18.3 хувь хүрсэн байна. Байгууллага, иргэдийн хүсэлтээр хадгаламжийн нэгжээс олгосон хуулбар, лавлагааны баримт /хуудсаар/ өмнөх онд бууралттай байсан бол тайлант онд 73.9 хувийн өсөлт үзүүлжээ.

Хүснэгт 16. Архивын сан хөмрөгийн ашиглалт, баримт бичгийн эргэлтийн мэдээ

Үзүүлэлт	Он	Тоо
Нийт албан бичгийн эргэлт	2017	15,900
	2018	18,817
Хоногийн албан бичгийн эргэлт	2017	66.2
	2018	75
Архив дахь хадгаламжийн нэгж	2017	13,758
	2018	15,594
Архиваас олгосон хуулбар лавлагаа	2017	3,089
	2018	5,372

4.3. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН)-ийн бүх ажлын хэсэгт ажиллаж, зохион байгуулагдсан хурал, семинарт оролцож, манлайллыг нэмэгдүүлэх, бүс нутгийн болон хөгжлийн ижил түвшний улсуудтай Монгол Улсын туршлагыг хуваалцах зорилтыг амжилттай хэрэгжүүлээ.

Тус нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн Төв Азийг төлөөлсөн гишүүн Хорооны дарга С.Даваасүрэн нь “Зүүн Европ, Төв Азийн Бүс нутгийн санхүүгийн хүртээмжийн зөвлөл” байгуулах санаачилга гаргаж, 2018 оны 9 дүгээр сард СХН-ээс ОХУ-ын Сочи хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн бодлогын форум”-д оролцсоны үр дүнд бүс нутгийн зөвлөлийг албан ёсоор байгуулж, СХН-тэй хамтын ажиллагааг өргөжүүлсэн. Зөвлөл нь СХН-ийн бодлогыг бүс нутагт хандуулах, гишүүн улсуудын бодлого боловсруулагчидтай хамтран ажиллах, Евразийн санхүүгийн хүртээмжид тулгамдаж буй асуудлуудыг олон улсын хүрээнд түлхүү таниулж, СХН-ийн хүрээнд шийдвэрлэх тогтолцоог бий болгох зорилготой юм.

Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг (СҮА) –тай хамтын ажиллагааны хүрээнд жил бүр 4 албан хаагчийг СҮА-ийн дэргэдэх Олон улсын санхүүгийн түншлэлийн төвд үнэт цаас, даатгалын салбарын хяналт шалгалтын чиглэлээр богино болон дунд хугацааны сургалтуудад хамруулах, СҮА-аас зохион байгуулдаг олон улсын хурал, семинарт хамрагдаж, туршлага солилцон, байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлээ.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-ээс хэрэгжүүлсэн “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” /RPF I ASIA II/ хөтөлбөрт 2016–2018 хооронд хамрагдсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад хүртээмжтэй даатгалыг нэвтрүүлэх, түүний зохицуулалтын орчинг бий болгох, мөн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүртээмжтэй даатгал болон хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагуудыг тодорхойлж, зохицуулалтын орчны үнэлгээ, даатгалын бүтээгдэхүүний судалгааг тус бүр хийсэн. Мөн уг хөтөлбөрийн дэргэдэх Хүртээмжтэй даатгалын асуудлаарх харилцан мэдлэг, туршлага солилцох сүлжээний Удирдах зөвлөлийн даргаар Хорооны дарга С.Даваасүрэн томилогдон Монгол Улсад төдийгүй Азийн бүс нутагт хүртээмжтэй

даатгалыг хөгжүүлэх, даатгалын салбарт төр болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилтод ажлуудыг дэмжин ажиллалаа. Мөн ГОУХАН-ийн дэмжлэгтэйгээр “Дэлхийн манлайллын академи”-тай хамтран “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-ийг 2017 оны 11 дүгээр сараас 2018 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлсэн. Хороо энэхүү төсөлд оролцож, хамтран ажилласнаар олон улсын туршлагад суурилсан хүртээмжтэй даатгалын шинэлэг зохицуулалтын орчинг нэвтрүүлж, иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх боломжийг бий болгосон.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-тай хамтран “Монгол Улсын Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх стратеги” техник хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцооны төлбөрийн эсрэг нийлүүлэлт болон Т+2/3 зарчмыг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд холбогдох дүрэм журам, зөвлөмжүүдийг боловсруулахаар ажиллаж байна. Мөн тус банкны дэмжлэгтэйгээр Монгол Улсын “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийн шинэчилсэн төсөлд эрх зүйн зөвлөмж гаргуулах ажлыг хамтран хэрэгжүүлж эхэлсэн.

ХНБГУ-ын СХШБ-тай техник хамтын ажиллагааг өргөжүүлэхээр хил дамнасан санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулсан.

БНСУ-ын СХШБ-ын хэрэгжүүлж буй “Санхүүгийн хяналт шалгалтын түншлэлийн хөтөлбөр”-т хамрагдаж ажлын байран дээрх сургалтын гэрээг байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд БНСУ-ын СХШБ-ын ажлын төв дээр зохион байгуулдаг дунд хугацааны сургалтад 4 албан хаагч, богино хугацааны сургалтад 9 албан хаагч хамрагдсан.

Монгол Улсын санхүүгийн салбарыг хөгжүүлэх, бүс нутгийн санхүүгийн интеграцид нэгдэх, Хорооны чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон улсын хандивлагч байгууллагууд, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагууд, олон улсын мэргэжлийн холбоод болон гадаад орны санхүүгийн зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд Дэлхийн банк (ДБ), Азийн хөгжлийн банк (АХБ), ЕСБХБ, ГОУХАН, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА) зэрэг олон улсын хандивлагч байгууллагуудтай одоо хэрэгжүүлж буй төслийн санхүүжилтийг

нэмэгдүүлэх, шинээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ХБНГУ-ын СХШБ, БНСУ-ын СХШБ, Австралийн Үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо (ҮЦХОХ)-той техникийн хамтын ажиллагааг өргөжүүллээ. Мөн түүнчлэн олон улсын мэргэжлийн холбоодын хүрээнд Хорооны байр суурийг бэхжүүлж манлайллыг нэмэгдүүлэх, гишүүн орнуудтай бодлогын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах зэрэг шинэ боломжуудыг бий болголоо.

Олон улсын хөрөнгө оруулалтын банк (ОУХОБ)-тай 2017 онд байгуулсан техникийн туслалцааны харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу тус банкны гишүүн Словак улсын засгийн газраас буцалтгүй тусламж үзүүлж Монгол Улсын санхүүгийн салбарын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) эрх зүйн орчныг сайжруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлсэн. Төслийг хэрэгжүүлэх байгууллагаар Словакийн Ernst & Young компани ажилласан бөгөөд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох төслийн эхний үе шатыг хэрэгжүүлж дууссан. Төслийн хүрээнд “Сэжигтэй гүйлгээг таньж мэдэх, мэдээлэх журам”, “Газар дээрх болон зайны хянан шалгалтын журам”-уудыг боловсруулах, МУТСТ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Засгийн газрын харья байгууллагууд болон бусад байгууллагуудын албан хаагчдад сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

МУТСТ чиглэлийн арга зүй, хяналт, шалгалтыг сайжруулах АХБ-наас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “МУТСТ шинэ нэгжийн гарын авлага”, “Харилцагчийг таньж мэдэх гарын авлага”-уудыг боловсруулах, Хорооны албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.

МУТСТ чиглэлийн үйл ажиллагааг сайжруулах, нөхцөл байдлыг дүгнэх, үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлогын талаар Монголбанк, Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдын холбоо, Прайсватерхаус компани болон холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан. Үүний үр дүнд МУТСТ үйл ажиллагаанд үүсч буй асуудлуудын талаар эрх бүхий байгууллагуудад танилцуулж, шийдвэр гаргуулах, үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын хуулийн төслийг боловсруулахад талуудын үүрэг оролцоог тодорхойлох ажлуудыг хэрэгжүүлэв.

4.4. ТӨСӨВ, САНХҮҮ

Төсвийн тухай хуулиар Хорооны даргын багцад 3,834.7 сая төгрөгийн төсөв батлагдсан ба үүнд, хөрөнгө оруулалтын болон гадаад төслийн зээл, тусламжийн зардал тусгагдаагүй. Нийт батлагдсан төсвийн орлогын 78.6 хувь буюу 3,012.3 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 21.4 хувь буюу 822.4 сая төгрөгийг зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлогын эх үүсвэрээр бүрдүүлэхээр төлөвлөсөн. Улсын төсвөөс олгосон санхүүжилтээс 203.2 сая төгрөгийг тайлант оны эцэст буцаан төвлөрүүлсэн.

Мөн зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлогоос 2,134.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь 1,312 сая төгрөгөөр буюу 159 хувиар давж биелсэн. Нийт орлогын 41.7 хувь буюу 890.9 сая төгрөгийг ББСБ-ын салбар, 30.5 хувь буюу 651.2 сая төгрөгийг үнэт цаасны зах зээл, 26.3 хувь буюу 560.4 сая төгрөгийг даатгалын зах зээл, 1.07 хувь буюу 22.9 сая төгрөгийг ХЗХ-ны салбарын зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс, 3.5 сая төгрөгийг бусад орлогоос төвлөрүүлсэн байна. Мөн торгуулийн орлого 144.9 сая төгрөг, тэмдэгтийн хураамжийн орлого 54.5 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлээ.

Төсвийн байгууллагуудыг хэмнэлтийн зарчмаар ажиллах УИХ-ын тогтоолын дагуу зарим зардлыг санхүүжүүлээгүй ч, төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн зарцуулж, Хорооны үйл ажиллагааг жигд, тасралтгүй хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажиллалаа.

Хороо нь олон улсын “СХН”-ийн гишүүн орны хувьд 130.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцох зэргээр гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн.

2018 оны санхүүгийн жилд даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх олгох, даатгалын салбарт аудит хийх чиглэл олгох мэргэжлийн сургалтыг 1 удаа хийж 7.2 сая төгрөгийн, үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх аудитор, хуульч, үнэлгээчдэд зориулсан мэргэжлийн сургалтыг 1 удаа хийж 12.3 сая төгрөгийн, нийт 19.5 сая төгрөгийн сургалтын орлого төвлөрүүлж, сургалтын зардалд зарцуулсан.

Түүнчлэн 2018 оны санхүүгийн жилд өр төлбөрийг бүрэн барагдуулж, найдваргүй авлага үүсгээгүй, тооцооны өглөгийг нэмэгдүүлээгүй зэрэг төсвийн тогтоомж зөрчилгүй ажилласан болно.



Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн Газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо